

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЭНТИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

ХЭНТИЙ АЙМГИЙН АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



**УЛААНБААТАР
2017**

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЭНТИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

ХЭНТИЙ АЙМГИЙН АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Боловсруулсан:

“Эко үйлчилгээ” ТББ байгаль орчны мэргэжлийн
байгууллага захирал С. Батдорж

Хэлэлцсэн:

Хэнтий аймгийн ЗДТГ, ИТХТ

Хүлээн авсан:

Хэнтий аймгийн Байгаль орчин Аялал жуулчлалын
газрын дарга Б. Дархантөр

УЛААНБААТАР
2017

ХЭНТИЙ АЙМГИЙН АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ӨМНӨХ ҮГ

НЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

- 1.1. Менежментийн төлөвлөгөөний үндэслэл
- 1.2. Менежментийн төлөвлөгөөг боловсруулсан аргачлалын тойм
- 1.3. Аймгийн физик газарзүй, биологийн олон янз байдлын онцлог
- 1.4. Нийгэм эдийн засгийн нөхцөл
- 1.5. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон орон нутгийн хамгаалалттай газрын сүлжээ
- 1.6. Агнуурын амьтдын төлөв байдал
- 1.7. Ан амьтны амьдрах орчны үнэлгээ

ХОЁР. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО

- 2.1. Ан агнуурын менежментийн тухай ойлголт, хамгааллын менежментийн өнөөгийн байдал
- 2.2. Менежментийн төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчмууд
- 2.3. Менежментийн төлөвлөгөөний онцлог, ач холбогдол

ГУРАВ. МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, СТРАТЕГИ

- 3.1. Алсын хараа, эрхэм зорилго
- 3.2. Хамрах хүрээ
- 3.3. Хамгаалахаар сонгосон амьтны зүйл, тэдгээрийн амьдрах орчин, идэш тэжээлийн бүлгэмдэл, экосистем тэдгээрийн өнөөгийн байдал амьдрах чадварын үнэлгээ
- 3.4. Хамгаалахаар сонгосон амьтны зүйл, тэдгээрийн амьдрах орчин, идэш тэжээлийн бүлгэмдэл, экосистемд учирч буй аюул дарамтын үнэлгээ
- 3.5. Ан агнуурын менежментийн төлөвлөгөөний зорилт
- 3.6. Зорилтыг хэрэгжүүлэх арга зам/стратегии

- 3.7. Стратегийг хэрэгжүүлэх эхний нэг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, санхүүгийн эх үүсвэр
- 3.8. Агнуурын бүс нутгийн танилцуулга, холбогдох газрын зураг, хилийн зааг, хэмжээ

ДӨРӨВ. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ, МОНИТОРИНГ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР

- 4.1. Үнэлгээ мониторинг
- 4.2. Амьтныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах үйл ажиллагааны удирдлагын бүтэц
- 4.3. Төсөв, санхүүгийн эх үүсвэр

ӨМНӨХ ҮГ

Экологийн тэнцвэрт байдал алдагдаж буй сүүлийн жилүүдэд дэлхий нийтээр байгалийн нөөцийн хамтын, тогтвортой менежментийн талаарх үзэл баримтлал, тухайлбал байгаль хамгаалах ажилд орон нутгийн иргэдийн оролцоог хангах, тэдгээрийн нөөц бололцоонд тулгуурлан биологийн төрөл зүйлийг хамгаалах, зүй зохистой ашиглах асуудал хурцаар тавигдаж байгаа билээ.

Хэнтий аймгийн нутагт агнуурын ач холбогдолтой аргаль хонь, цагаан зээр, халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахай, монгол тарвага, мах идэшт, агнуурын шувууд байршдаг бөгөөд тэдгээрийн экосистемд гүйцэтгэх үүрэг нь асар их юм. Аймгийн хэмжээнд тодорхой газруудад агнуурын зарим хөхтөн амьтад (аргаль хонь) шинээр нутагшиж, тоо толгой өсөж, тогтворжих хандлагатай байгаа нь сайшаалтай боловч нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд нүүрлэж буй байгаль цаг уур, хүний шууд болон дам хүчин зүйлийн улмаас бүс нутгийн хөхтөн амьтны хэвийн тогтвортой байршил алдагдах, тоо толгой нь цөөрөх, тархац нутгийн зарим хэсэгт ховордон байхгүй болох зэргээр хөхтөн амьтдын элдэв хэлбэрт нөлөөлөх үйл ажиллагаа өдрөөс өдөрт эрчимжиж байна.

Аймгийн БОАЖГ нь ан амьтдыг хамгаалах, сэргээн нутагшуулах, шинжлэх ухааны үндэслэлтэй, тогтвортой, зүй зохистой ашиглах талаар санаачилгатай ажиллаж монгол тарвага сэргээн нутагшуулах ажлыг мэргэжлийн байгууллагууд, ТББ-ууд, орон нутгийнхны оролцоотой хэрэгжүүлсэн байдаг. Хэнтий аймгийн хэмжээнд үндэсний болон олон төсөл хөтөлбөрийн хүрээнд тал хээрийн, уулын туруутан болон монгол тарваганы агнуур зохион байгуулалтын судалгааг харилцан адилгүй цаг хугацаанд гүйцэтгэж байсан боловч өнөөг хүртэл менежментийн төлөвлөгөө боловсруулан, батлагдаж байгаагүй байна.

Хэнтий аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө нь 2017-2022 онуудад хэрэгжих бөгөөд энэхүү төлөвлөгөөнд бүс нутгийн экосистемийн хэв шинжид дасан зохицож амьдарч буй биологийн олон янз байдал, ялангуяа ховор болон агнуурын ач холбогдолтой хөхтөн амьтдын популяцийг хамгаалах ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр, орон нутгийн удирдлага нутгийн иргэдийн оролцоог зохистой хэлбэрээр хангах, учирч буй аюул, дарамтыг бууруулж, хамгаалах талаар гаргасан саналыг тусгасан болно.

Энэхүү менежментийн төлөвлөгөө нь ан амьтдын тоо толгой, нөөцийг хамгаалахад оролцогч талуудын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр байх бөгөөд түүнийг

хэрэгжүүлэхдээ орон нутгийн төр захиргааны байгууллага, мэргэжлийн байгууллагууд, нөхөрлөлүүдийн чадавх, нөөц бололцоонд тулгуурласан хамтын ажиллагааг бий болгох, ингэснээр хамгаалалт, зохистой ашиглалт, тогтвортой байдлыг хангах боломж бүрдэх болно.

Төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол улсын төр, Засгийн газар, аймгаас агнуурын зүйлүүдийг хамгаалах, зохистой ашиглах талаар баримталж буй бодлогод тулгуурласны зэрэгцээ өмнө хийгдсэн судалгаануудын тайлан, судлаачдын зөвлөмж, саналыг нь үндэслэн хамгааллын стратеги, зорилт, үйл ажиллагааг төлөвлөсөн болно.

Менежментийн төлөвлөгөөний бүтэц нь 4 бүлгээс бүрдэх бөгөөд менежментийн төлөвлөгөөний үндэслэл, зорилго, аймгийн хэмжээний агнуурын хөхтөн амьтдын өнөөгийн төлөв, бүс нутгийн биологийн болон нийгэмд эдийн засгийн өнөөгийн байдал, учирч буй бэрхшээл, эрсдэлд хийсэн үнэлгээ, төлөвлөгөөний зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд болон тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг оруулсан болно.

Нэр томьёоны тайлбар

“Агнуурын бүс нутаг” гэж агнуурын нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах зориулалт бүхий ан амьтны байршил, тархац нутгийг; (“Амьтны тухай” хууль)

“Агнуурын сан” гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дэх унаган, нутагшсан буюу нүүдлийн агнуурын хөхтөн амьтан, шувуу, загасны бүрдэл. (“Амьтны тухай” хууль)

“Ан агнуурын менежментийн төлөвлөгөө” гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх агнуурын бүс нутагт ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн агнуур зохион байгуулалтын ажлын тайлан, дүгнэлтийг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ан агнах, барих зөвшөөрөл олгоход үндэслэл болох баримт бичгийг; (“Амьтны тухай” хууль)

“Агнуурын амьтан” гэж арьс, үс, мах болон бусад түүхий эдийг нь ашиглахаар агнаж ирсэн уламжлалтай, агнуурын нөөцтэй амьтныг, (“Амьтны тухай” хууль)

“Агнуурын нөөц” гэж агнуурын амьтны биологийн нөөцөөс хэвийн өсөлт, үржилтийг алдагдуулахгүй агнах, барих боломжтой тоо хэмжээ (“Амьтны тухай” хууль)

“Трофейн буюу олзворын ан” ан амьтны илүү үзүүлэлт бүхий эд, эрхтнийг авах зорилгоор тусгай төлбөр төлж агнах, барих үйлийг (“Амьтны тухай” хууль);

“Спорт ан” гэж анчин ан агнах, барих хэрэгцээгээ хангах зорилгоор ан амьтны эд, эрхтнийг үзүүлэлтийн хувьд сонголт болголгүй агнах, барих үйлийг (“Амьтны тухай” хууль);

“ан агнуур” гэж ангийн гаралтай түүхий эдийг ашиглах зорилгоор хуулиар заасан хугацаа, арга, хэрэгсэл, зөвшөөрлийн дагуу агнуурын амьтныг агнах, барих үйл ажиллагааг;

“агнуурын зохион байгуулалт” гэж агнуурын амьтны тархац, байршил, нөөц, төрөл, зүйл, тоо толгой, сүргийн бүтэц, өөрчлөлтийг судлан тогтоож, агнуурын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, өсгөн үржүүлэх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлох үйл ажиллагааг;

“байгалийн нөөцийн хамтын менежмент” гэж нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан нутгийн иргэдэд байгалийн нөөцийг дундаа хариуцан хамгаалах, зохистой ашиглах болон нөхөн сэргээх эрхийг олгож, нутгийн иргэд нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс нийгэм, эдийн засгийн ашиг тусыг хүртэж байх үйл явцыг байгалийн нөөцийн хамтын менежмент гэнэ.

Товчилсон үгийн тайлбар

АЗБ	- Агнуур зохион байгуулалт
БОАЖЯ	- Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОХУБ	- Байгаль орчны хяналтын улсын байцаагч
БОАЖГ	- Байгаль орчин Аялал жуулчлалын газар
НИТААМ	- Нутгийн иргэдэд түшиглэсэн ан агнуурын менежмент
ОНХГ	- Орон нутгийн хамгаалалттай газар
НҮТББ	- Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага

НЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

1.1. Менежментийн төлөвлөгөөг боловсруулах хууль-эрхзүйн үндэслэл

Хурдацтай хөгжиж буй өнөө үед эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, хүрээлэн буй орчныг хамгаалах, нөөц баялаг түүний дотор агнуурын санг хамгаалах, тоо толгойг өсгөн үржүүлэх, зүй зохистой ашиглахтай холбоотой цогц арга хэмжээг шат дараалан авч хэрэгжүүлсний үр дүнд тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин харьцангуй сайн бүрэлдсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар шинэчлэн батлагдсан “Амьтны тухай” хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарсан журмуудад агнуурын нөөцийг хамгаалах, зүй зохистой, тогтвортой ашиглалтыг дэмжих зорилгоор газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах буюу “агнуурын бүс нутаг”-ийг бий болгох улмаар тэдгээрийн хамгаалалтыг бэхжүүлэх, менежментийг нь сайжруулах эрх зүйн орчин тусгагдсан байдаг. Амьтны тухай хуулийн 4.1.11 дэхь заалтад тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх агнуурын бүс нутагт ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн ан агнуурын арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн баримт бичиг нь “**ан агнуурын менежментийн төлөвлөгөө**” байна гэж тусгажээ.

“Амьтны тухай” хуулийн 21-р зүйлийн 4 дэх хэсгийн “Агнуурын нөөцийг хамгаалах зорилго бүхий мэргэжлийн байгууллага нь агнуурын нөөц, түүний тооллого бүртгэл, агнуур зохион байгуулалтын ажлыг улс, орон нутгийн болон иргэн, хуулийн этгээдийн захиалга, хөрөнгөөр гүйцэтгэх, тэдгээрийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулах” хууль эрхзүйн заалтуудыг үндэслэл болгон Хэнтий аймгийн БОАЖГ-ын захиалга, санхүүжилтээр байгаль орчны мэргэжлийн байгууллага Эко үйлчилгээ ТББ ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааны ажлыг гүйцэтгэх БО/2017/01 тоот гэрээг байгуулан, тус аймгийн нутаг дэвсгэрийг бүрэн хамруулан анхдагч мэдээ хэрэглэхүүн бүрдүүлэх хээрийн судалгааг гүйцэтгэн, энэхүү тайлан мэдээнд үндэслэн аймгийн хэмжээнд ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

Менежментийн төлөвлөгөө боловсруулах байгаль хамгааллын үндэслэл

Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах зорилгоор боловсруулсан менежментийн төлөвлөлт нь тухайн байгалийн нөөц, баялагт хүний үйл ажиллагаанаас одоо болон ирээдүйд гарч болзошгүй сөрөг нөлөөг тодорхойлох, түүний учир шалтгааныг олон арилгах, бууруулах зөв арга замыг хайх замаар боловсруулдаг.

Хэнтий аймгийн нутагт ховор болон ховордсон хөхтөн амьтад болох аргаль хонь, ойн туруутан, монгол тарвага, агнуурын ач холбогдолтой цагаан зээр, саарал чоно, шар үнэг, хярс үнэг зэрэг хөхтөн амьтад, идлэг шонхор, жороо тоодог гэх мэт ховор шувууд зайцан байршдаг онцлогтой.

Төр засгаас дээр нэр дурдсан ховор болоод агнуурын ач холбогдолтой амьтдын популяцийн хэвийн өсөлт үржлийг алдагдуулахгүй, тогтвортой байлгах чиглэлээр олон арга хэмжээ авч байна. Гэвч эдгээр амьтдын тархац нутгийн зарим хэсэгт малын тоо толгойн хэт өсөлттэй уялдан бэлчээр, усны хомсдол үүсэж, эзэмшил нутгийн давхцал бий болж, бэлчээр талхлагдаж байна. Уул уурхайн үйлдвэрлэл, ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагааны улмаас эдгээр амьтад байршил нутгаасаа дайжих, тоо толгой нь цөөрөх, тархац нутаг нь хумигдах болов. Урьдчилсан тооцоо төлөвлөгөөгүйгээр хэт их агналтаас үүдэн бүс нутгийн монгол тарваганы тоо толгой эрс буурсан болох нь сүүлийн үед хийгдсэн судалгааны шинжилгээний ажлын үр дүнгээс харагдах болов.

Энэ мэтчилэн бүс нутгийн хүрээлэн буй орчин, биологийн олон янз байдал хүний шууд болон дам нөлөөлөл, байгалийн хүчин зүйлээс шалтгаалан тэнцвэрт байдал алдагдаж байгаа нь тэдгээрийг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатайг харуулна. Эдгээр арга хэмжээнд аймгийн нутаг дэвсгэрт ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн агнуур зохион байгуулалтын ажлын тайлан, дүгнэлтийг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөх, амьтны нөөц бүхий агнуурын бүс нутгийн байгалийн нөөцийн хамгаалал, зохистой ашиглалтын менежментийг нутгийн иргэдэд (байгаль хамгаалах нөхөрлөлд) хариуцуулах замаар байгалийн нөөцийн хамтын менежментийг бий болгох явдал тооцогдоно.

1.2. Менежментийн төлөвлөгөөг боловсруулсан аргачлалын тойм

Хэнтий аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг Америкийн нэгдсэн улсын Де Нэйчэ Консерванси төрийн бус байгууллагын боловсруулсан САР буюу Байгаль хамгааллын үйл ажиллагааны тасралтгүй үргэлжлэх, давтагдах, сайжруулах үйл явцыг агуулсан процесс бүхий төлөвлөлт боловсруулдаг арга зүйг ашиглан боловсруулав. Учир нь тус нутгийн зөвхөн агнуурын амьтныг хамгаалах, зохистой ашиглах асуудал бус, харин хамгаалахаар сонгон авсан ховор болоод агнуурын амьтан нь тухайн экосистемийн үйл явцын нэг бүрэлдэхүүн хэсгийн хэмжээнд үзсэн.

Зөвхөн ховор болоод агнуурын хөхтөн амьтад төдийгүй биологийн янз байдлыг тогтвортой байлгахад зорилтот буюу зайлшгүй хамгаалах амьтан, экосистемийг сонгон зорилго дэвшүүлсэн бөгөөд уг зорилтот бүлэгт одоо болон ирээдүйд тулгарч буй аюул, дарамтыг тодорхойлох, зорилт боловсруулах, шаардлагатай үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, эцэст нь үр дүнг дүгнэх, дахин асуудлыг тодорхойлох, төлөвлөх гэх мэтээр үргэлжлэх тасралтгүй процесс гэж ойлгоно. (Зураг-1).



Зураг 1. Байгаль хамгааллын үйл ажиллагаа

Байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах менежментийн төлөвлөгөөг боловсруулах үйл явц нь үндсэн 4 үе шаттай.

1.1. Аймгийн физик газарзүй, биологийн олон янз байдлын онцлог

Хэнтий аймаг нь хойгуураа ОХУ-тай 300-аад км, зүүнээрээ Дорнод, зүүн урдуураа Сүхбаатар, урдуураа Дорноговь, баруун урдуураа Говьсүмбэр, баруунаараа Төв аймгуудтай хиллэн 80.3 мянган хавтгай дөрвөлжин км талбай бүхий нутаг эзлэн (Зураг 2) оршино.

Аймгийн төв Өндөрхаан Улаанбаатар хотоос 331 км зайд, Хэрлэн голын хөвөөнд далайн түвшнээс дээш 1027 м өндөрт, х.ө 47°19', з.у 100°40'-ийн солбицолд оршино. Аймгийн нутгийн хойд захын цэг нь Дадал сумын нутгийн хойд захад Балж голын зүүн гарын цутгал Хар голын хөндийд х.ө 49°24'48-д, өмнөд захын цэг нь Галшар сумын нутгийн өмнөд захад х.ө 46°03'12, баруун захын цэг нь Цэнхэрмандал сумын нутгийн баруун захад Хэрлэн голын баруун гарын цутгал Хуцын голын адагт з.у 108°23'42-д, зүүн захын цэг нь Баян-Овоо сумын нутгийн зүүн захад Хэрлэнгийн Батхаан овоо з.у 112°43'30-д оршдог аж. Хойд захын цэгээс өмнөд захын цэг хүртэл 371 км, зүүн захын цэгээс баруун захын цэг хүртэл 324 км зайтай. Аймгийн нутгийн төв хүйс нь х.ө 47°44, з.у 110°33'36-ын солбицолд Өндөрхаан хотоос хойш 49.0 км, Хэрлэн сумын Ишгэн багийн төвөөс баруун хойш 16.0 км оршино. Нарангийн булгийн хойно орших овооноос хойш нэг км орчимд урагшаа хандсан аманд далайн түвшнээс дээш 1200 орчим метр өндөрт оршиж байна.

Хүн ам. Одоо Хэнтий аймаг 18 сум, 4 тосгон, 88 багтай. Тус аймаг ойт болон тал хээр хосолсон 80.3 мянган хавтгай дөрвөлжин км газар нутагтай, нийт 23 мянга 800 өрх, 73600 хүн амтай, үүнээс эрэгтэй, 37,3, эмэгтэй 36,3 мянга байна. Хүн амын 87.4% нь халх, 5477 нь буриад, гадаадын харьяат, 244, хасаг 463, урианхай 779, дарьганга 281, баяд 117, дөрвөд 371, бусад ястан үндэстэн 500 гаруй хүн байна. 2016 оны эцсээр 48.4 мянган хөдөлмөрийн насны хүн байна. Ажил эрхлэлтийн түвшин 56.2 хувь, ажилгүйдлийн түвшин 12.9хувь байна.

ХАА-н байдал. 2016 оны жилийн эцсийн байдлаар Хэнтий аймаг 3903,6 мянган толгой мал, үүний дотор 4,3 мянган тэмээ, 280.8 мянган адуу, 296.2 мянган үхэр, 1938.1 мянган хонь, 1384.1 мянган ямаа тоолуулж, урьд оноос мал сүрэг 1901.6 мянган толгойгоор өссөн байна. Мөн 3,9 сая толгой малтай бөгөөд мал сүргийн тоогоороо улсдаа 6 дугаар байр эзэлдэг, өвлийн бэлтгэл байгалийн хадлан 125,4 мян/тн хураан авсан байна. ДНБ-ний үйлдвэрлэл 344,6 сая төгрөг. Үүний 60,1%-ийг ХАА-н салбар ,12,2%-

ийг аж үйлдвэрийн салбар, 27,7%-ийг үйлчилгээний салбар эзэлж байна. Энэ оны байдлаар 246 нутгийн брэнд бүтээгдэхүүн байна.

Тус аймаг нь 2016 онд үр тариа 24792,0 га-д, улаан буудай 23872,0 га-д, төмс 349,2 га-д, хүнсний ногоо 362,2 га-д тус тус тариалж, Аймгийн хэмжээнд үр тариа 9517,4 тн, төмс 3818,7 тн, хүнсний ногоо 2477,3 тн, 9380,4 тн улаан буудайг тус тус хураан авсан.

Хэнтий аймгийн уур амьсгал. Монгол орны ерөнхий байдал шинжийг хадгалсан эх газрын эрс тэс уур амьсгалтай. Гэвч аймгийн нутгийг хойд ба өмнөд хэсэг болгон авч үзвэл уур амьсгалын байдал дунд зэргийн ялгаатай байдаг. Энэ нь аймгийн нутаг урдаасаа хойшоо өргөргийн хувьд даруй 3°-ын зөрөөтэй байгаа учраас газар нутгийн нарнаас авах дулааны хэмжээ ойролцоогоор 3°-ын зөрөөтэй байх магадлалыг дагаж хойд сумдын нутаг сэрүүсэх хандлага илэрнэ.

Агаарын температур. Жилийн дундаж дулаан нь хамгийн өмнө захын нутгаар 0 хэмээс дулаан, дунд хэсгээрээ Онон Балжийн сав орчмоор 0-2 хэм, хойд хэсгийн уулархаг нутгаар -2-4 хэм байна. Өндөрхаан хотод долоодугаар сард дунджаар +18.7 хэм, хамгийн их дулаан болсон нь +38.9 хэм, нэгдүгээр сард дунджаар -23.4 хэм, хамгийн их хүйтэн болсон нь -46.3 хэм хүрч байжээ.

Хур тунадас. Өмнө захын нутгаар 200-250 мм, дунд хэсгээрээ 250-300 мм, Өндөрхаанд 260 мм, хойд хэсгийн уулархаг нутаг, Онон Балжийн сав нутгаар 300-400 мм, Хэнтий ханы өндөр уулсад 500 мм тунадас унадаг. Тогтвортой цасан бүрхүүл өмнөд хэсгийн нутгаар 12-р сарын 1-ний үед тогтож, 100 орчим хоног цастай байж, 3 дугаар сарын 1-ний үед ханзарна. Хойд хэсгийн нутгаар цасан бүрхүүл 11-р сарын 1-10-ны үед тогтож 4-р сарын 10-наас 5-р сарын 1-ний үед ханзарна. Ган болох магадлал өмнөд хэсгийн нутгаар 30%, хойд хэсгийн нутгаар 20 орчим хувь байна. Уур амьсгалын мужлалын хувьд төвийн болон өмнөд хэсгийн нутгаар хуурайдуу сэрүүн зунтай хахирдуу өвөлтэй, хойд хэсгийн нутгаар чийгтэй сэрүүвтэр зунтай, хахир хахирдуу өвөлтэй нутагт багтана.

Хэнтий аймгийн нутагт баруун хойт болон хойт зүгийн салхи зонхилно. Ялангуяа хавар их салхитай байдаг. Тэмдэглэгдсэн салхины хамгийн их хүчтэй нь 28-40 м/с хүрч байсан бол нийт нутгаар жилд дунджаар 1-20 өдөр шороон шуурга шуурдаг байна.

2017 оны 3 сарын байдлаар Агаарын сарын дундаж температур -5,9 хэм буюу олон жилийн дунджаас 1,7 хэмээр дулаан байлаа. Сарын дундаж температурыг олон жилийн дундажтай харьцуулбал Гурванбаян, Норовлин, Баян-овоо сумд олон жилийн дунджаас 0,3 - 1 градус хүйтэн, Өлзийт тосгонд олон жилийн дунджийн орчим, бусад сумд дунджаас 1 – 4 градус дулаан байв. Агаарын сарын дундаж температурын хамгийн дулаан Дархан суманд -3,3 хэм, хамгийн хүйтэн Гурванбаян суманд -9,2 градус байлаа. Агаарын температурын хамгийн их утга 10,2...14,6 градус дулаан байж сарын үнэмлэхүй их температур Батширээт суманд 14,6 градус хүрсэн байна. Агаарын температурын хамгийн бага утга -16,8...-29,1 градус хүйтэн. Үнэмлэхүй бага утга Өлзийт тосгонд -29,1 градус хүрч хүйтэрсэн байна.

Ландшафт. Хэнтийн гол нуруу, Их Хэнтий, Бага Хэнтий хэмээх салбар уулуудын өндөрлөг хамрагддаг тул гадаргын бүтцийн хувьд өндөр уул, дундаж өндөр уулын хэв шинжит хотгор, гүдгэр зонхилно. Аймгийн нутаг дэвсгэрт ян сарьдаг, уулын таг, уулын тайга, уулын хээр, намагт нугын гэсэн 5 хэв шинжээс гадна уулын тайгыг умардын ба өмнөдийн, татмын болон намагт нугын дэд ландшафтууд тархсан байна.

Хэнтий аймгийн ус. Аймгийн гадаргын ус нь Номхон далай, Хойд мөсөн далай, Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамрагддаг. Монгол оронд томоохон тооцогдох Хэрлэн, Онон, Улз гол нь Номхон далайн ай савд, Минж гол түүний цутгал голууд Хойд мөсөн далайн ай савд тус тус хамрагдана. Номхон далайн ай савын голууд өндөр уулсаас эх авч урсах тул ихэнхдээ голын сүлжээ их шигүү, урсгал хурдтай, уналт ихтэй байдаг. Аймгийн нутгаар Хэрлэн гол 580 орчим км, түүний цутгал Тэнүүн, Тэрэлж, Мөрөн, Цэнхэр, мөн Онон гол 390 гаруй км урсах бөгөөд түүний цутгалууд Хурх, Шуус, Барх, Балж болон Улз голууд урсана. Нууруудын хувьд Гурваннуур, Хар зүрхний Хөх нуур, Гүрмийн нуур, Аваргын нуур болон Хэрлэнгийн савд жижиг жижиг нуурууд олон байдаг.

Тус аймаг нь манай орны рашаан ус элбэгтэйд тооцогддог. Гурван нуур, Улаалзгана, Онон, Тард, Арангат, Тосон нуур зэрэг рашаан ус байдаг. Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага, Норовлин, Дадал сумын нутаг дэвсгэрийг дамжин урсдаг Онон, Хэрлэн, Улз гол Номхон далайн ай савд, Өмнөдэлгэр сумын нутаг Минж гол, түүний цутгал голууд Хойд мөсөн далайн ай савд, Төв Азийн гадагш урсгалгүй ай савд Дархан, Галшар сумын багахан нутаг дэвсгэр хамрагддаг. Аймгийн усан сан бүхий

ангиллын газар нь нийт нутаг дэвсгэрийн 1.1% буюу 88.4 мян.га эзэлнэ. Үүний 81.2 мян.га буюу 91.9%-ийг гол мөрөн, 7.0 мян.га буюу 7.9%-ийг нуур, цөөрөм, 182.3 га буюу 0.2%-ийг горхи, булаг, рашаан тус тус эзэлдэг. 2011 оны гадаргын усны улсын тооллогоор аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 379 гол, 836 булаг, 20 рашаан, 312 нуур нийт 1547 гадаргын усны байршил тоологдсон байна. Үүнээс 67 гол горхи, 366 булаг, 5 рашаан, 105 нуур хатаж, ширгэсэн дүн гарсан байна. Нийт хатаж ширгэсэн гол 17.7%, булаг 43.8%, рашаан 25%, нуур 33.7% -ийг эзэлж, нийт уст цэгийн 35.1% хатаж ширгэсэн байна.

Экосистем. Хэнтий аймгийн нийт газар нутгийг Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын хийсэн экосистемийн ангиллаар авч үзэхэд газар тариалан 829.1 км², байнгын урсацтай гол, голын татам 7257.3 км², өндөр уулын сарьдаг 131.4 км², өндөр уулын хээр 66.2 км², нугархаг хээр 23359.1 км², суурин газар 357.7 км², түр зуурын урсацтай гол, сайр 120.6 км², тагийн нуга 519.3 км², холимог ой 8972.2 км², хотгор, цайдам 449.9 км², цөлөрхөг хээр 727.5 км², уулын тайга 3671.6 км², хуурай хээр 17489.4 км², хуурайдуу хээр 16841.1 км² газар нутгийг тус тус эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан нутгийн газарзүйн онцлог: Монгол улсын нутаг дэвсгэр нь эрс тэс уур амьсгалтай, экологийн эмзэг бүсэд хамрагддаг бөгөөд Төв Азийн цөлийн хойт хэсэг, Сибирийн тайгын урд хэсгийн өргөн уудам газар нутагт орших байрлал, шилжилтийн бүсийн онцлог бүхий экосистемийн хослол нь Монгол орны ургамал, амьтны төрөл зүйлийн өвөрмөгц бүрэлдэхүүнийг нөхцөлдүүлдэг. Монгол орны газрын гадаргын онцлогтой зохицсон ургамалжилтын 6 бүс, бүслүүр байдаг. Хэнтий аймгийн газар нутаг ургамалжилтын доорх бүс, бүслүүрт хамаардаг.

Өндөр уулын тагийн бүслүүр. Хэнтий уулсын оройн хэсэгт ойн бүслүүрээс дээш тохиолддог тачир өвслөг ургамалтай нуга, намхан сөөгөн ширэнгэ, хаг хөвдөт царам зэрэг ургамалжилтын өвөрмөгц хэвшлүүдтэй. Энд зонхилох ургамлын ихэнх нь олон болон нэг наст өвслөг ургамал, сөөг, сөөгөнцөр тохиолдоно.


Уулын тайгын бүслүүр. Уулын тайгын үндсэн хэв шинж нь хуш, хуш-шинэсэн ой болдог. Уулын тайгад модноос хуш, сибирь шинэс, гацуур, сибирь жодоо, одой хус, сөөг сөөгөнцрөөс алирс, хар нэрс, сибирь арц, алтайн далан хальс, зузаан навчит бадаан, улбар сорвоо, сибирь удвал, суман согоо, азийн жамьянмядаг зэрэг ургамлууд зонхилно.

Уулын ойт хээрийн бүслүүр. Энэ бүслүүрийн хээрийн хэв шинжид хамаарах элдэв өвс үетэнт, хялганат, хазааргана-хялганат, агь-хялганат, ботууль агьт, уулын хээр, ойн үндсэн хэв шинжид хамаарах өвслөг ургамалт саруул шинэсэн ой, нарсан ой, хус-шинэс-нарсан холимог ой тохиолдоно.

Хээрийн бүс. Хуурайсаг өвслөг ургамал зонхилсон нутгийг хээр гэнэ. Хээрт хуурайсаг, дэгнүүлт ба үндэслэг ишт үетэн, элдэв өвслөг ургамал зонхилно.

Нуга, намаг, усны ургамал. Эдгээр нь өндөр уул, ой, тайгын бүслүүр, хээр цөлийн бүсийн алинд ч тохиолдож болно. Нуга дунд чийгшилтэй газар ургасан өвслөг ургамлаас бүрдэл болсон ургамлын бүлэг юм.

Хэнтий аймгийн ургамал, газар зүйн мужлал. Хэнтий уулын тайгын тойрог, Монгол дагуурын уулын ойт хээрийн тойрог, дундад халхын хээрийн тойрогт хамаардаг. Хэнтий аймгийн ургамлын аймагт 89 овог, 387 төрөлд хамаарах 1139 зүйл гуурст ургамал бүртгэгдсэн байна.



Зураг 2. Хэнтий аймгийн экосистем

1.2. Агнуурын амьтдын төлөв байдал

Хэнтий аймгийн нутагт агнуурын ач холбогдолтой олон амьтад тархан байршдагаас бид аргаль хонь, ойн туруутан, монгол тарвага зэрэг ховор болоод агнуурын ач холбогдолтой хөхтөн амьтдыг сонгон авч тоо толгой, нөөцийн үнэлгээг гүйцэтгэн, бүс нутгийн биологийн олон янз байдлын төлөөлөл болгон тэдгээрийг хамгаалах, зүй зохистой ашиглах үндэслэлийг боловсруулан гаргасан. Аливаа газар нутгийн хөхтөн амьтдын өнөөгийн статус, хууль эрхзүйн баримт бичгээр хамгаалагдсан байдлыг тодруулан үзэх нь тэдгээрийг хамгаалах, өсгөн үржүүлэх зүй зохистой менежментийг төлөвлөхөд чухал ач холбогдолтой үндсэн бүрэлдэхүүн хэсгийн нэг болдог. Эдгээр хөхтөн амьтад үндэсний болон олон улсын хууль эрхзүйн актаар хамгаалагдсан байдлыг дор харуулав.


ЕРӨНХИЙ АГНУУР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ГОЛ ДҮГНЭЛТҮҮД

Аргаль хонины тархац, байршил, тоо толгой.

Хамгааллын статус: Олон улсын үнэлгээ (IUCN, 2010)-ээр эмзэг зүйл (vulnerable species), бүс нутгийн үнэлгээгээр (IUCN, 2006) устаж болзошгүй (endangered species) зүйлийн ангилалд тус тус хамрагдсан. Аргаль хонь нь Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES), Нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)-ийн II хавсралт (UNEP-WCMC, 2006)-д тус тус бүртгэгджээ. Үндэсний хэмжээнд 1953 оноос агнахыг хуулиар хориглосон бөгөөд Монгол улсын ховор амьтны жагсаалтад Засгийн газрын 2012 оны 7-р тогтоолоор бүртгэсэн. Монгол улсын улаан номын 3 удаагийн хэвлэл (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997, Шийрэвдамба нар, 2013)-д ховор зүйл хэмээн тодорхойлсон. Аргаль хонь нь трофейн агнуурын чухал амьтан бөгөөд тусгай зориулалтаар угалзыг 7-р сарын 01-нэс 10-р сарын 01 хүртэл агнах ба ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агналтыг хоригложээ.

Дэлхий дахинд: Аргаль хонины 9 зүйлхэнээс 7 зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай (CITES) конвенцийн II хавсралтад, харин *O.a. bodgsonii*, *O.a.nigrimontana* хоёр хамгийн их аюулд өртсөн учраас 1-р хавсралтад оруулсан байна. IUCN-ийн Улаан номонд алтайн аргаль хонийг маш эмзэг, говийн аргаль хонийг ховордсон (IUCN 2004) гэсэн ангилалд оруулсан байна.

Бүс нутгийн аргаль хонины популяцийн төлөв байдал. Тус аймаг дахь аргаль хонины тархац нутагт хийгдэж байсан судалгааны мэдээ, материал болон агнуур зохион байгуулалтын энэхүү ажлын хээрийн судалгаагаар Дэлгэрхаан сумын Хэрлэнбаян-Улаан уулын Баянбулаг, Хөхтий, Дулаан, Барын ам, Дөтлүүрийн мухар, Хэрлэн тооно уул, Дархан сумын Дархан хан уул, Эргэнэг, Бор уул, Өлгий уул, Баянмөнх сумын Эргэнэг, Язаарын уул, Баянхутаг сумын Баян уул, Буян уул, Баянхүрээ уул, Галшар сумын Их арт, Залаа, Цана, Баянхан, Үнэгт, Галшар уул, Мөрөн сумын Хатан, Хар өндөр, Бага улаан, Их улаан, Эхэн ус, Гамал, Салбар уул, Баян-Овоо сумын Зүүн Хадтай ууланд аргаль хонь тархан нутаглаж байна.




Зураг 3. Хэнтий аймгийн аргаль хонины тархац нутаг

Тоо толгой, нягтшил, нөөцийн үнэлгээ. Хэнтий аймгийн нутагт улсын хэмжээгээр хийсэн аргаль хонины тооллогоор 598 км² нутагт 175 тоо толгой, 2002 оны аймгийн агнуур зохион байгуулалтаар Дархан, Галшар, Баянмөнх, Дэлгэрхаан сумдын нутагт нийт 773 км² нутагт 172 тоо толгой, 2009 оны уулын туруутны нөөц үнэлгээний нэгдсэн тайлангийн дүгнэлтээр тус аймгийн Галшар, Дархан, Баянмөнх, Дэлгэрхаан, Мөрөн сумдын нутгийн 14 газрын 682.5 км² талбайд нийт 180 толгой аргаль хонины нөөцтэй гэж тэмдэглэгдэж байжээ.

2012 оны ерөнхий агнуур зохион байгуулалтын хээрийн судалгаагаар Дэлгэрхаан сумын Хэрлэнбаян-Улаан уулын Баянбулаг, Хөхтий, Дулаан, Барын ам, Дөтлүүрийн

мухар, Хэрлэн тооно уул, Дархан сумын Дархан хан уул, Эрэгнэг, Батмөнх сумын Эрэгнэг, Язаарын уул, Баянхутаг сумын Баян уул, Буян уул, Баянхүрээ уул, Галшар сумын Их арт, Залаа, Цана, Баянхаан, Үнэгт, Галшар уул, Мөрөн сумын Хатан, Хар өндөр, Бага улаан, Их улаан, Эхэн ус, Гамал, Салбар уул, Бор-Өндөр сумын Бор уул, Өлгий уулын нийт 977.62 км² талбайд тархаж 435 толгой аргаль хонь 10 км² талбайд 4.5 бодгаль нягтшилтай байна. Мөн Баян-Овоо сумын Зүүн хадтай, Улаан цахиуртад өнгөрсөн 2011 оны намар нэг аргаль хонь ирсэн нь одоо 2 толгой болон нэмэгдсэнээс үзэхэд аргаль хонь зүүн тийш тархац нутгаа тэлж байна гэж болохоор байна. Бор-Өндөр тосгоны Бор уул, Өлгий ууланд аргаль хоньтой болохыг шинээр тогтоосон байна.



Зураг 4. Хэнтий аймгийн аргаль хонины тоо толгойн өөрчлөлт

Ерөнхий агнуур зохион байгуулалтын 2012 оны судалгааны дүнг 2009 оныхтой харьцуулан үзвэл тархац нутгийн хэмжээ 27,8%-и, нэгж талбай дахь нягтшил 36,3%-и, нөөцийн хэмжээ 51,9%-и тус тус нэмэгдсэн байна.

Бид судалгааны дүнгээ нэгтгэн Биологийн хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн хурлаар баталсан орчин үеийн арга зүй, компьютер програмаар боловсруулан Хэнтий аймгийн нутагт тархсан аргаль хонины нийт нөөцийн үнэлгээг сум тус бүрээр тодорхойлон гаргаснаа 1-р хүснэгтэд цэгцлэн үзүүлэв.

Хүснэгт 1. Аргаль хонины нөөцийн үнэлгээ

Сумын нэр	Байршил нутаг (км ²)	Цөм байршил (км ²) /St/	Сорилын талбай (км ²) /Ssd/	Ажиглагдсан бодгаль /Ns/	Нийт нөөц /Nt/
Баянхутаг	231	33	8.4	15	59±8
Баянмөнх	252	84	56.1	47	70±8


Дархан	752	336	225.41	105	157±13
Дэлгэрхаан	988	637	361.18	70	123±11
Галшар	375	390	152.75	17	53±7
Мөрөн	168	72	8.5	5	42±7
Нийт	2766	1552	812.34	259	505±72

2017 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар аймгийн **2766 км² нутагт 505±72 толгой аргаль хонь 1000 га-д 1,7 бодгаль** ногдох нягтшилтай байна.

Цагаан зээрийн тархац, байршил, тоо толгой

Хамгааллын статус: Монгол улсын “Амьтны тухай” хуулиар ахуйн хэрэгцээний зориулалтаар цагаан зээрийг 9-аар сарын 1-нэс 12-аар сарын 1 хүртэл агнаж болох бөгөөд агнах цагаан зээрийн нас, хүйс, тоо толгойн хэмжээг энэ хуулиар тодорхойлоогүй байна. Байгаль орчны сайдын 2000 оны тушаалаар цагаан зээрийг үйлдвэрлэлийн зориулалтаар агнахыг хоригложээ. ДБХХ-ны жагсаалтад цагаан зээрийг анхааралд өртөхөөргүй гэсэн ангилалд хамруулжээ. Монгол орны хөхтөн амьтны улаан дансанд “Устаж болзошгүй” гэсэн үнэлгээ өгсөн байдаг. Монгол улсын “Амьтны тухай” хуульд цагаан зээр түгээмэл тархацтай, “элбэг” зүйлийн тоонд ордог бөгөөд Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах Бонын конвенцийн II-р хавсралтанд бүртгэгдсэн байна. Цагаан зээр нь тал хээрийн экосистемийн үндсэн төлөөлөгч төдийгүй арьс махны агнуурын чухал амьтан.

Бүс нутгийн цагаан зээрийн популяцийн төлөв байдал. Тус аймгийн цагаан зээр нь Цэнхэрмандал сумын Зүүн хаяа, Хэрлэнгийн эрэг дагуу, Дэлгэрхаан сумын Хэрлэн тооно уулын зүүн тал, хэрлэн голын эрэг, Баянмөнх сумын Их, Бага цагаан ус, Зүүн, Баруун толь ус, Хүнхийн тал, Баян дал, Хөл хөндлөн, Гогронт, Цагаан нуур, Хаяатын үзүүр, Ухаа, Завхан тал, Хотгорын ухаа, Галшар сумын нийт нутгаар, Баянхутаг сумын Хөдөө эрээн, Төгрөг, Жаргалант, Хулгарын ухаа, Их Арт уулын ар, Хужирт, Баян-Овоо сумын Тосон хулстай, Сүмбэр уул, Есөн хун, Зүүн хадтай, Хөх Өндөр, Биндэр сумын Баян тал, Хавчуу, Дөш, Шар Өндөр, Уйлант, Урт бор овоо, Хувьтай, Баруун, Зүүн ухаа, Их могой, Эмээлтийн хөх чулуу, Батширээт сумын Навчит, Биндэр овоо, Сүүл толгой, Нөмөр хааны овоо, Нүүргэстэй, Баян-Адрага сумын Баянгол, Ар гурван булаг, Цагаан тэмээд, Сүүл Өндөр, Сайханы хөндий, Шуусын гол зэрэг газраар цагаан зээр тархан байршдаг байна.



Зураг 5. Хэнтий аймгийн цагаан зээрийн тархац нутаг

Тоо толгой, нягтшил, нөөцийн үнэлгээ. Хэнтий аймагт 38500 км^2 талбайд 288.000 ± 32.950 тоо толгой цагаан зээр байршиж, 10 км^2 талбайд 747 ± 36.7 толгой цагаан зээр ногдох нягтшилтай байжээ (Лхагвасүрэн, 2000).

Биологийн хүрээлэнгээс гүйцэтгэсэн 2009 оны судалгаагаар Төв аймгийн өмнөд хэсэг, Хэнтий, Дорноговийн зүүн хойт хэсгийн нутаг 281030 толгой цагаан зээр 1000 га-д 28 бодгаль ногдох нягтшилтайгаар 95% магадлалаар 99978-789940 цагаан зээртэй гэсэн бол Монголын анчдын нийгэмлэг 2012 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар тус аймгийн нутагт 50-60 мянган толгой цагаан зээр тогтвортой байршин нутаглаж, намрын сүүл, өвлийн улиралд Дорнод, Сүхбаатар аймгаас нүүдэллэн орж ирж, популяцийн хэмжээ 3-4 дахин нэмэгдэж 200-225 мянган нөөцтэй болохыг тогтоосон байдаг. 2014 оны судалгаагаар тус аймагт нийт 30 сүргийн 3197 цагаан зээрийг нүдээр үзэж бүртгэсэн бөгөөд сүргийн дундаж 106.6 ± 41.8 бодгаль, хамгийн багаар нэг сүрэгт 7, хамгийн ихээр 1200 бодгаль, VII сард 37094.4 км^2 нутагт 61232 ± 12246 толгой цагаан зээр 1000 га-д 17 ± 3 бодгаль ногдох нягтшилтай, Харин намрын буюу X сарын судалгаагаар цагаан зээр 1000 га-д 32 ± 6 бодгаль ногдох нягтшилтай 116505 ± 23301 толгой байх боломжтойг тус аймгийн 2014 оны судалгаагаар тогтоожээ.

Хүснэгт 2. Цагаан зээрийн тоо толгой, нөөцийн үнэлгээ

Үзүүлэлтүүд	2000 он	2009 он	2012 он	2014 он	2017 он
Тархац нутаг (км ²)	38500	35446		37094.4	32041.0
Нэгж талбай дахь нягтшил (D), (сүргийн нягтшил $\hat{D}_s$)	747 ± 36.7	2.75 (0.0075)		17±3	9.4±3.1
Нөөц $\hat{N}$		281030			31338
95%-ийн магадлалтай хязгаар (95% CI)	288.000±32.950	99978-789940)	200,000- 225,000	61232±12246	12964-50939

Хэдийгээр байгаль цаг уурын тааламжтай нөхцөлд бие гүйцсэн шаргачны 60-85%, дунджаар 82% төллөн, ихэрлэлд 2-8%, дунджаар 5% байж (Лхагвасүрэн, 2000) 2-3 жилийн дотор цагаан зээрийн популяци 2 дахин өсөх биологийн бүрэн чадавхтай (Эрэгдэндава, 1997) болохыг судлаачид дурдсанаас үзэхэд энэхүү тоо толгойн өсөлт явагдах боломжтой.

Хүснэгт 3. Цагаан зээрийн нөөцийн үнэлгээ (сумдаар)

Сумын нэр	Байршил нутаг (км ²)	Цөм байршил (км ²) /St/	Сорилын талбай (км2) /Ssd/	Ажиглагдсан бодгаль /Ns/	Нийт нөөц /Nt/	Хязгаар-95% CI
Батноров	3721.0	2633.2	128.4	209	4286	1208-6057
Батширээт	78.0	58.2	22.0	58	153	78-233
Баян-Адрага	763.4	79.1	9.6	48	395	225-3817
Баян хутаг	5473.1	4399.8	335.0	298	3914	2055-4869
Баянмөнх	2419.9	2160.4	205.7	279	2930	1570-4371
Баян-Овоо	2460.9	1605.1	158.4	329	3334	703-5111
Биндэр	95.5	55.5	24.3	58	132	50-287
Дадал	22.1	12.1	3.0	61	246	163-449
Дархан	2763.2	1867.3	137.4	292	3968	1906-5872
Дэлгэрхаан	1524.9	609.2	26.6	99	2267	685-5676
Галшар	5422.6	4547.7	365.0	284	3538	1692-4115
Хэрлэн	1332.6	199.5	25.7	23	179	70-247
Жаргалтхаан	845.9	222.1	24.0	84	777	314-1075
Мөрөн	1023.4	152.0	0.0	0		
Норовлин	1851.6	1851.6	121.0	329	5034	2144-7756
Өмнөдэлгэр	2242.947	407.3	156.4	70	182	101-1004
Нийт	32041.0	20860.1	1742.5	2521.0	31338	12964-50939


2017 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар *Хэнтий аймгийн цагаан зээрийн тархац, байршил бүхий 32041,0 км² нутагт 31338 (95% CI=12964-50939) толгой цагаан зээр, нэгж талбайд 9,4±3,1 нягтшилтайгаар тархан нутаглаж байгааг тогтоов.*

Халиун бугын тархац, байршил, тоо толгой

Хамгааллын статус: Бүс нутгийн үнэлгээгээр (IUCN, 2006) устаж байгаа (critically endangered species) зүйлийн ангилалд хамрагдсан. Халиун буга нь Монгол улсын ховор амьтны жагсаалтад 2012 оны 7-р тогтоолоор бүртгэгджээ. БОЯ-нас олгосон тусгай зөвшөөрлийн дагуу агнадаг.


Дэлхий дахинд: Дэлхийн байгаль хамгаалах холбооны (IUCN) Улаан дансанд *C.Elaphus*-ийг анхааралд өртөхөөргүй гэсэн (1994) гэж ангилалд оруулжээ. Үүнээс өөр энэ зүйлийн худалдаа болон амьдрах орчныг зохицуулах ямар нэг гэрээ хэлэлцээр байхгүй.

Бүс нутгийн халиун бугын популяцийн төлөв байдал. Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Баян, Намдаг, Адуун чулуун, Дэлгэрхаан сумын Хэрлэнбаян улаан уул, Дархан сумын Дархан хан уул, Батширээт сумын Их, Бага Сүүхлэг уул, Алаг уул, Шарангуун уул, Гурван Улаан хөндий, Гүнталхаан, Турагтхаан, Тарсын Тэрсгэр уул, Хөх гозгор уул, Хужирын шар өндөр уул, Биндэр сумын Улиастайн эх, Төөрдөгийн шил, Балжийн эх, Дөрвөлж уул, Норовлин сумын Цагаан овоо, Бухт, Гахайт, Номгон уул, Бөөр, Цагаанчулуут, Улаан даваа, Баян-Адрага сумын Баян-Өндөр, Дунд Бичигт, Улиастай, Уртын гол, Дадал сумын Өвөр Улаалгана, Дэлэв, Халзай, Хавтгайн хар, Хүрэн өндөр, Сөөгт, Эрээн, Мөрөн сумын Өндөрхаан уул зэрэг газарт халиун буга тархан байршиж байна. Д. Энхтүвшин нар Хан хэнтийн ДЦГ-ын орчмын бүсийн 7778 км² газарт 385 толгой буга байршиж байгааг тогтоосноос үзэхэд дээрх бүс нутагт 1000 га-д 0.4 бодгаль нягтшилтай байна.



Зураг 6. Хэнтий аймгийн халиун бугын тархац нутаг

Тоо толгой, нягтшил, нөөцийн үнэлгээ. 2002 оны агнуур зохион байгуулалтаар 6235 км² нутагт 211 тоо толгой, 2010 онд хийсэн популяцийн үнэлгээгээр Хэнтий нуруунд 14459 км² нутагт 1864 (95% CI=1215-2805) толгой халиун буга идээшин нутаглаж, тархац нутгийн 1000 га буюу 10 км² талбайд 1.3 бодгаль ноогдох нягтшилтай. 2012 оны аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтаар 7659 км² нутагт 1000 га-д 2.1 бодгаль ноогдох нягтшилтайгаар 1608±80.1 толгой халиун буга тархан байршиж байгааг тогтоожээ.



Зураг 7. Хэнтий аймгийн халиун бугын тоо толгойн өөрчлөлт

Халиун буга өмөнх оноос тархац нутгаа тэлэх, тоо толгой өсөн нэмэгдэх хандалгатай байна.

Хүснэгт 4. Халиун бугын нөөцийн үнэлгээ

Сумын нэр	Байршил нутаг (км ²)	Цөм байршил (км ²) /St/	Сорилын талбай (км ²) /Ssd/	Ажиглагдсан бодгаль /Ns/	Нийт нөөц /Nt/
Дадал	1318.61	241.92	38	50	318±18
Дархан	14.04	11.20	10.7	15	16±4
Батширээт	3570.75	1225.39	180	154	1048±32
Баян-Адрага	81.06	5.73	2.5	37	85±9
Биндэр	1239.31	497.68	29.7	15	251±16
Өмнөдэлгэр	2935.91	589.47	45.1	49	640±25
Дэлгэрхаан	223.11	11.93	4.6	19	49±7
Норовлин	231.41	29.28	14.2	30	62±8
Цэнхэрмандал	1048.37	79.72	13.6	18	106±10
Нийт	10662.58	2692.32	338.40	387	3079±236

2017 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар тус аймгийн 10662,58 км² нутагт 3079±236 толгой (95% CI=1928-5825) халиун буга 1000 га-д 1,2 бодгаль ногдох нягтшилтай байна.


Бор гөрөөсний тархац, байршил, тоо толгой.

Хамгааллын статус: Бор гөрөөс (*Capreolus pygargus*) нь мах, эмчилгээ, арьсны уламжлалт ан бөгөөд Монгол улсад ахуйн зориулалтаар 8-р сарын 1-нэс 12-р сарын 1 хүртэл агнахыг зөвшөөрдөг. Нас, хүйс, хэмжээг заагаагүй. Тоо толгойн бууралтад нөлөөлж болзошгүй хүчин зүйлүүдэд хууль бус агнуур, амьдрах орчны доройтол зэрэг орно. Бор гөрөөсний тархац нутгийн 13 хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг (Улаан данс 2006).

Дэлхий дахинд: Элбэг тохиолдох зүйлийн жагсаалтад ордог. Бор гөрөөс (*Capreolus pygargus*) нь CITES, IUCN болон бусад олон улсын гэрээнүүдэд тусгагдаагүй.

Бүс нутгийн бор гөрөөсний популяцийн төлөв байдал. Хэнтий аймгийн ойт бүсийн бүх нутаг, бутлаг ургамал бүхий бэсрэг толгодоор тархсан. Тархац нутаг нь уудам, тоо толгой элбэг зүйл. Тоо толгой, нягтшил газар бүр адилгүй. Тухайлбал: 1000 га дахь


дундаж нягтшил Хэнтийн Бүрх голын савд 14, Хэрлэнбаян Улаанд 10 толгой байсныг доктор С.Дуламцэрэн 1966-1975 онд хийсэн судалгаагаар гаргажээ. Эдгээр судалгаан дээр үндэслэн Хангай, Хэнтийн мужид 50 мянга орчим толгой бор гөрөөстэй гэж тогтоосон байна(Дуламцэрэн, 1977). Доктор Д. Энхтүвшиний 2000-2003 онд хийсэн судалгаагаар Хан Хэнтийн ДЦГ-ын орчны бүсэд 1000 га-д 0.9 толгой ноогдох нягтшилтай болохыг тогтоожээ. Орон нутгийн иргэд, байгаль орчны улсын байцаагч, албаны хүмүүсээс авсан судалгааны үр дүнгээр бор гөрөөс сүүлийн жилүүдэд элбэгшиж байгаа бөгөөд агнуур зохион байгуулалтын хээрийн судалгаагаар (2012 оны) тархац нутгийн 1000 га-д дунджаар 3.7 бодгаль ноогдох нягтшилтайгаар 3242 ± 184 толгой бор гөрөөс нийт 8763 км² нутагт тархан байршиж байгааг тогтоосон байна.



Зураг 8. Хэнтий аймгийн бор гөрөөсний тархац нутаг

Тоо толгой, нягтшил, нөөцийн үнэлгээ. 2002 оны агнуур зохион байгуулалтаар 12758 км нутагт 1379 тоо толгой, Улсын хэмжээнд зохион байгуулагдсан ойн туруутны тооллогоор тус аймгийн 16875 км² нутагт 4527 (95% CI=2930-7022) бор гөрөөс байршил нутгийн 1000 га-д 1.6 бодгаль ноогдох нягтшилтай, 2012 оны ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгаагаар тархац нутагт 1000 га-д дунджаар 3.7 бодгаль ноогдох

нягтшилтайгаар 3242 ± 184 толгой бор гөрөөс нийт 8763 км^2 нутагт тархан байршиж байгааг тогтоосноос өөр Хэнтий аймгийн бор гөрөөсний тоо толгой, нөөцтэй холбогдох мэдээ хэрэглэхүүн одоогоор байхгүй байна.



Зураг 9. Хэнтий аймгийн бор гөрөөсний тоо толгойн өөрчлөлт

Бор гөрөөсний тоо толгойн хэлбэлзэл нь судалгааны өөр өөр арга зүйтэй холбоотой боловч, хүний үйл ажиллагаа, ойн түймэр, хууль бус агнуураас шалтгаалдаг. Мөн үүнээс гадна тархац нутаг хэвийн байхад тоо толгой цөөрөх хандлага нь ойн туруутан амьтдын байршил нутгийн өрсөлдөөн, харилцан хамааралтай холбоотой байдаг. Судлаачид халиун бугын тоо толгой өсөхтэй холбоотой эсрэгээр бор гөрөөсний тоо толгой цөөрөх зүй тогтол байдгийг тэмдэглэсэн байдаг. Хэнтий аймгийн бор гөрөөсний тоо толгойн өөрчлөлт энэ зүй тогтолтой хамааралтай болох нь судалгааны явцад ажиглагдсан.

Хүснэгт 5. Бор гөрөөсний нөөцийн үнэлгээ

Сумын нэр	Байршил нутаг (км^2)	Цөм байршил (км^2) /St/	Сорилын талбай (км^2) /Ssd/	Ажиглагдсан бодгаль /Ns/	Нийт нөөц /Nt/
Батширээт	4088.0	1797.6	140.5	117	1497 ± 38
Баян-Адрага	785.3	103.0	45.2	45	103 ± 12
Бидэр	2561.5	942.9	31.4	28	841 ± 28
Дадал	3901.8	2189.7	365.7	55	329 ± 18
Норовлин	652.5	357.1	104.6	24	82 ± 9
Өмнөдэлгэр	2588.6	958.7	115.3	148	1231 ± 35
Цэнхэрмандал	697.1	187.9	101.5	53	98 ± 9
Нийт	15274.8	6536.8	904.2	470	3398 ± 252


2017 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар тус аймгийн $15274,8 \text{ км}^2$ нутагт 3398 ± 252 толгой бор гөрөөс 1000 га-д 2,2 бодгаль ногдох нягтшилтай байна.

Зэрлэг гахайн тархац, байршил, тоо толгой.

Хамгааллын статус: Зэрлэг гахай (*Sus scrofa*) нь уламжлалт анд тооцогдож ирсэн бөгөөд монгол улсад ойн зэрлэг гахай (*S.sc sibiricus*), зэгсний зэрлэг гахай (*S.sc. nigripes*) гэх хоёр зүйлхэн бий. Монгол улсын Улаан номонд зэгсний зэрлэг гахай (*S.sc. nigripes*) нь нэн ховор зэрэглэлээр орсон байна. Амьтны тухай хуулиар агнах хугацааг 8-р сарын 1-нээс 12-р сарын 1 хүртэл байхаар тогтоосон. Зэрлэг гахайн тархац нутгийн 13 хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг байна (Улаан данс 2006).

Дэлхий дахинд: Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн худалдааны статуст зэрлэг гахай ороогүй. ДБХХ-ны 1994 Улаан номонд эрсдэл багатай, тусгай анхааралд авах шаардлагагүй гэж ангилжээ. Энэ зүйлийг худалдаалахыг зохицуулсан өөр ямар нэгэн гэрээ хэлэлцээр Монголд байхгүй.


Бүс нутгийн зэрлэг гахайн популяцийн төлөв байдал. Тархцын хувьд Хангай, Хэнтийн ой бүхий нутгийн хүрээг бараг бүхэлд нь хамарна. Үргэлжийн эрчимтэй агнуураас болж Хэнтийн тайгаас бусад ихэнх нутагт ховорджээ. Хан Хэнтийн ДЦГ-ын орчмын бүсэд 1000 га-д 0.4 толгой ноогдох нягтшилтай гэж Д.Энхтүвшин 2003 онд тогтоосон байна. Сүүлийн жилүүдэд Хэнтий аймгийн зэрлэг гахай тархсан нутгуудад байгаль цаг уурын таатай нөхцөл бүрэлдэн самрын ургац тогтвортой байж идэш тэжээлийн хангамж сайжирсан зэргээс түүний тоо толгой хэд дахин нэмэгдэх бололцоотой болжээ.



Зураг 10. Хэнтий аймгийн зэрлэг гахайн тархац нутаг

Бидний судалгаагаар тус аймгийн зэрлэг гахай Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага, Дадал, Норовлин сумдын нутгийн ойтой хэсэгт байрших бөгөөд нутаглах боломжит байршил нутаг нь 7174,47 км² байх бөгөөд үүнээс хамгийн тохиромжтой цөм байршил нутаг 2162,24 км² байна.

Тоо толгой, нягтшил, нөөцийн үнэлгээ. Хэнтий аймагт 2002 оны агнуур зохион байгуулалтаар 5447 км² нутагт 215 тоо толгой, Улсын хэмжээнд зохион байгуулагдсан ойн туруутны тооллого, судалгаагаар 16977 км² нутагт 5332 (95% CI=3171-8340) зэрлэг гахай байршил нутгийн 1000 га-д 2.9 бодгаль ноогдох нягтшилтай. 2012 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар нийт 5973 км² нутагт 1000 га-д 2.3 бодгаль ноогдох нягтшилтайгаар 1373±68.3 зэрлэг гахайн нөөцтэйг тогтоосон байна.



Зураг 11. Хэнтий аймгийн зэрлэг гахайн тоо толгойн өөрчлөлт

Зэрлэг гахайн тоо толгойн хэлбэлзэл нь хүний үйл ажиллагаа, ойн түймэр, хууль бус агнуураас шалтгаалдаг боловч ойн туруутан амьтдын байршил нутгийн өрсөлдөөн, харилцан хамааралтай холбоотой байдаг. Судлаачид халиун бугын тоо толгой өсөхтэй холбоотой эсрэгээр бор гөрөөс, зэрлэг гахайн тоо толгой цөөрөх зүй тогтол байдгийг тэмдэглэсэн байдаг. Хэнтий аймгийн зэрлэг гахайн тоо толгой, тархац нутгийн өөрчлөлт энэ зүй тогтолтой хамааралтай төдийгүй сүүлийн жилүүдэд самар их хэмжээгээр түүх болсонтой холбоотой болох нь судалгааны явцад ажиглагдсан.

Хүснэгт 6. Зэрлэг гахайн нөөцийн үнэлгээ

Сумын нэр	Байршил нутаг (км ²)	Цөм байршил (км ²)/St/	Сорилын талбай (км ²)/Ssd/	Ажиглагдсан бодгаль /Ns/	Нийт нөөц /Nt/
Батширээт	2028.45	764.05	216.4	185	653±19
Баян-Адрага	32.66	32.66	19.6	29	48±8

Биндэр	1162.07	422.96	75	43	242±12
Дадал	2631.75	790.70	115.7	25	171±11
Норовлин	367.49	50.37	19.4	23	60±8
Өмнөдэлгэр	918.13	101.11	10.3	50	491±18
Цэнхэрмандал	33.93	0.39	0.1	16	63±10
Нийт	7174.47	2162.24	456.5	371	1757±186


2017 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар *тус аймгийн 7174.47 км² нутагт 1757±186 толгой зэрлэг гахай 1000 га-д 1,6 бодгаль* ногдох нягтшилтай байна.

Монгол тарваганы тархац, байршил, тоо толгой.

Хамгааллын статус: Олон улсын үнэлгээ (IUCN, 2010) болон бүс нутгийн үнэлгээ (IUCN, 2006)-ээр устаж болзошгүй зүйл (endangered species) ангилалд тус тус хамрагдсан. Монгол тарвага нь ховор болон нэн ховор амьтны жагсаалтад ороогүй. Монгол улсын Байгаль орчин, Ногоон хөгжлийн сайдын тушаалаар 2005-2007 онд орон даяар тарваганы агнуурыг бүрэн хориглосон, 2014 оны 02-р сарын 25-ны өдрийн А-61 дүгээр тушаалаар монгол тарвагыг агнуурын нөөц нь хангалттай өсөн нэмэгдэхгүй байгаа учраас ахуйн болон үйлдвэрлэлийн зорилгоор 3 жилийн хугацаатай агнахыг хориглосон байна. Гэсэн хэдий ч байгаль цаг уурын таагүй нөхцөл, хууль бус агнуур тодорхой хэмжээнд буурахгүй байгаа тул 2017 оноос дахин 3 жилээр агнахыг хориглосон. Монгол тарваганы тархац нутгийн 6 орчим хувь нь улсын тусгай хамгаалалттай газарт хамрагдсан.

Бүс нутгийн монгол тарваганы популяцийн төлөв байдал. Тарвага тус аймгийн нийт нутагт 2000 оноос өмнө элбэг тархацтай (1000 га-д 42 бүл) байсан боловч ган, зудын улмаас 2000 оноос эрс ховордож одоогийн байдлаар зөвхөн Цэнхэрмандал сумын цагаан ширээ, гурван түрүүний даваа, цэнхэр усны хөндий, сонгино, ганц байшинт, Дэлгэрхаан сумын Дэлгэрхаан уулын ар бэл, ар цэнхэр ус, хүнхий мааньт, цагаан гуяа, гурван түрүүний даваа \ нягтшил өндөр \, дархан сумын дархан хан уул, хоёр холбоо, Норовлин сумын модот дэл улаан, нүцгэн, улаан-өндөр, тэмээд, хаван, дагт, тэлмэн хаан, сүүл өндөр, хараат овоо, Баян-Адрага сумын ар гурван булаг, цагаан тэмээд, сүүл өндөр, сайхны хөндий, шуусын боом, шийр, биндэр сумын хавчуу наймаат, дөш, шар өндөр, уйланта, урт бор овоо, хувьтай, баруун, зүүн ухаа, их могой, эмээлтийн хөх чулуу, Батширээт сумын биндэр овоо, навчит, дал, залаа, нүүргэстэй, сүүл толгой, Нөмөрхааны овоо зэрэг газруудад байршин амьдарч байна. эдгээр газраас Норовлин, Батноров, Баян-Адрага

сумдын зааг цогтын хоолой, Цэнхэр мандал, Дэлгэрхаан сумын зааг ар цэнхэр ус, гурван түрүүний даваа орчимд 1000 га-д 20-30 бүлтэй нягтшил өндөр бөгөөд бусад дурдсан газарт цөөн бүлээр цэгэн голомт үлдсэн байна. аймгийн бусад нутагт бүрэн устаж алга болсон.



Зураг 12. Хэнтий аймгийн монгол тарваганы тархац нутаг


Тоо толгой, нягтшил, нөөцийн үнэлгээ. Хэнтий аймгийн нутагт тархсан монгол тарваганы тархац байршил, тоо толгойн үнэлгээг эрдэмтэн судлаачид харилцан адилгүй цаг хугацаанд судалж, өөрсдийн дүгнэлт тайланг гаргаж байв.

1990 оны судалгаагаар Хэнтий аймгийн хэмжээнд 16095,01 км² нутагт 900000 орчим толгой монгол тарвага тархаж байж. Дээрх судалгаанаас хойш 2002 оны агнуур зохион байгуулалтаар 19075 км² нутагт 79874 тоо толгой, 2002 оны Дорнод монголын тарваганы агнуур зохион байгуулалтаар 8926,8 км² нутагт 290515 тоо толгой, 2010 оны Хэнтий аймгийн зарим сумын нутагт тархсан монгол тарваганы тархац нөөцийн үнэлгээгээр 642,99 км² тархац нутагт 26822 тоо толгой, 2012 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар 690,43 км² нутагт 15344 тоо толгой тарваганы нөөцтэйг тогтоосон байна.

Баян-Адрага сумын нутгийн иргэдийн Алдар Анд нөхөрлөл 2011 онд Шуусын боомд 15 тарвага нутагшуулах ажил зохион байгуулсан нь сайшаалтай байна. Батноров,

Норовлин суманд 2015 онд 50 толой монгол тарвага. Галшар сумын Баянхан ууланд 3 жилийн өмнө 52 толгой тарвага сэргээн нутагшуулсан бөгөөд одоо өөр өөр нутагт шилжин байршиж 10-аад хэсэг нутагт цөөн тоогоор үзэгдэж байна. Өсөлт үржиж байгаа тухай мэдээлэл байхгүй байна (Байгадь хамгаалагч Тогоохүү аман мэдээ).

Батноров, Норовлин, Баян-Адарга сумдын нутагт мониторинг судалгаа хийсний үндсэн дээр тал хээрийн сумдад сэргээн нутагшуулах ажил зохион байгуулах боломжтой.



Зураг 13. Хэнтий аймгийн монгол тарваганы тоо толгой болон нөөцн өөрчлөлтийн судалгаа (он оноор)

Ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгаагаар дээрх сумдын тарвага тархсан талбайн хэмжээ 6362,4 км² буюу өмнөх судалгаагаар тогтоогдсон тарвага тархан байрших экологийн тохиромжтой нөхцөл бүхий нутгаа тэлэх хандлагатай байна.

Тус нутагт сүүлийн жилүүдэд байгаль цаг уурын тааламжит нөхцөлтэй байсан, улсын хэмжээгээр тарваганы хорио тогтоосон мөн сэргээн нутагшуулах зэрэг нь зарим бүс нутгийн монгол тарваганы хамгаалал, популяцийн өсөн үржихүйд таатай нөлөө үзүүлж, хуучин тархац болон үлдсэн голомтот нутагтаа сэргэж буй байдал ажиглагдаж байна.

Хүснэгт 7. Монгол тарваганы нөөцийн үнэлгээ

Сумын нэр	Тарвага тархсан талбай (км)	Сорилын талбай (км)	Ажиглагдсан бүлийн тоо	Бодгалийн тоо	Нөөцийн үнэлгээ	Нягтшил /км²/
Батноров	1521.93	72	26	42	888±130	5.8
Батширээт	51.58	10	5	40	206±15	40.0
Баян-Адрага	1021.54	225.1	36	263	1194±137	11.7
Баян-Овоо	0.11					
Биндэр	206.88	69	45	70	210±35	10.1

Дадал	56.32	22	7	56	143±32	25.5
Дэлгэрхаан	494.49	65	31	199	1514±139	30.6
Хэрлэн	314.48	159	4	13	26±5	0.8
Жаргалтхаан	545.37	195	4	51	143±12	2.6
Норовлин	1336.25	96	15	85	1183±134	8.9
Өмнөдэлгэр	286.89	77	31	128	477±122	16.6
Цэнхэрмандал	526.61	44	45	102	1221±135	23.2
Нийт	6362.44	1034.1	249	1049	7204±1393	11.3


2017 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт **6362,44 км² талбайд 7204±1393 толгой монгол тарвага** 100 га буюу 1 км² талбайд дунджаар 11.3 бодгаль ноогдох нягтшилтай байна.

Саарал чонын тархац, байршил, тоо толгой.

Хамгааллын статус: Махан идэштний баг (*Carnivoria* Bowdich., 1821), чонынхон овог (*Carniidae* Gray., 1821), чоно төрлийн (*Canis lupus* Linnaeus., 1758) үслэг ан, мах идэшт амьтан. Монголын саарал чоныг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнаж болно. Агнах улирал болон тоо хэмжээг заагаагүй. Саарал чоно нь ЗАУХЗХК-ийн 2-р хавсралтад орсон байдаг ба оршин байх орноос гарахдаа экспортын, хүлээн авах улсын импортын зөвшөөрөлтэйгөөр худалдаа хийдэг. Саарал чоно тоо толгой элбэг, өргөн уудам нутагт тархсан тул аюулд өртсөн ангилалд ордоггүй. Иймээс ДБХХ-ны Улаан номд анхааралд өртөхөөргүй ангиллаар Монгол орны хөхтөн амьтны улаан дансанд (2006) устаж болзошгүй ангиллаар үнэлсэн байдаг. Тухайн үед тал хээрийн бүсийн саарал чоно агнуурт ихээр өртөх болсонтой холбоотойгоор зүүн 3 аймагт агнахыг хориглосон шийдвэр гарч байсан. Гэхдээ зөвхөн дорнод монголын тэгш өндөрлөгт цагаан зээрийн сүргийг даган байршиж түүгээр идэшлэдэг нутгийн анчид “зээрийн цагаан” гэж нэрлэдэг чоно ховордсон харин Монгол орны бусад нутагт ялангуяа хангайн бүсийн чоно өсөж зэрлэг амьтад болон гэрийн малд халдах нь нэмэгдсэн гэж судлаачид тэмдэглэсэн байдаг.

Бүс нутгийн саарал чонын популяцийн төлөв байдал. Хэнтий аймгийн бүх сумдын нутагт өргөн тархах боловч өнөө үед тус аймгийн чонын тоо толгой задгай ландшафт болох тал хээрийн бүс, цөлөрхөг хээрээр багасаж тус аймгийн хойт хэсэг болох ой, ойт хээрийн болон уул нуруудын салбар уулс, хад бартаа саадтай нутгаар элбэгшсэн. Хэнтий аймгийн ОХУ -тай хиллэдэг хэсэг, Дадал, Биндэр, Батширээт, Баян-Адарга сумдын нутгаар нэлээд элбэг. Ой болон уулархаг бүс нутагтаа чоно хэвийн байршилтай

бөгөөд идэш тэжээл биологч амьтдаа даган хэвтээ болоод босоо бүслүүрийн дагуу шилжин байршдаг зүй тогтолтой.



Зураг 14. Хэнтий аймгийн саарал чононы тархац нутаг

Тоо толгой, нягтшил, нөөцийн үнэлгээ. 1985 онд Биологийн хүрээлэнгийн Хөхтний экологийн лабораториос 1986-1990 онд агнаж болох амьтны тоог “БНМАУ-ын агнуурын хөхтөн амьтны нөөц, агнах хэмжээ” зөвлөмжид тодорхойлж, Монгол орны агнуурын амьтдын тоо нөөц, агнах хэмжээг аймаг, сумдаар гаргажээ. Тухайлбал, Монгол орны хэмжээгээр нийт 30.8 мянга гаруй чонотой гэсэн тооцоог хийсэн байдаг. ШУА-ийн судалгаагаар 1980 онд Монголын популяци 30000 бодгаль гэж тооцоолсон байна. Саяхны судалгаагаар Монголд 10000-с бага бодгаль байж болох юм гэж үзсэн (Mech, Boitani, 2004) боловч эдгээр үнэлгээ хангалттай биш бөгөөд одоогийн тоог нарийвчлан тогтоох шаардлагатай байна. 2012 оны Хэнтий аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтаар 28094.1 км² тархац нутагт 957 толгой саарал чоно тархан байршиж байгааг тогтоосон байна.

Бид судалгааны явцад орон нутгийн малчид иргэдээс авсан өнгөрсөн хугацаанд саарал чоно харсан, гэрийн мал идэгдсэн эсэх талаарх аман асуулга, өөрсдийн судалгааны үр дүнг нэгтгэн үзвэл 3546 км² сорилын талбайд нийт 145 саарал чоно бүртгэгджээ

(хүснэгт 10). Саарал чонын тоо толгой тархац байршил нутагтай холбогдох аман мэдээлэл, биетээр үзэж тэмдэглэсэн орон зайн байршилд тулгуурлан саарал чонын амьдрах орчны загварчлалыг хийхэд тус аймгийн байгалийн олон бүс бүслүүрийг хамарсан 40778,7 км² нутагт тархан байрших боломжтой байна.

Хүснэгт 8. Саарал чонын нөөцийн үнэлгээ

Сумын нэр	Байршил нутаг (км2)	Сорилын талбай (км2) /Ssd/	Ажиглагдсан бодгаль /Ns/	Нийт нөөц /Nt/
Батноров	3502.7	271	7	90±10
Батширээт	5870.2	122.2	15	721±27
Баян-Адрага	1989.0	98.4	5	101±10
Баянхутаг	1890.8	289.7	6	39±6
Баянмөнх	103.4	11.6	7	62±8
Баян-Овоо	597.8	57.3	4	42±6
Биндэр	4115.1	125.5	11	361±19
Дадал	3729.9	121.5	9	276±17
Дархан	242.1	9.2	2	53±7
Дэлгэрхаан	1526.6	473.4	10	32±6
Галшар	621.9	75.7	5	41±6
Хэрлэн	1901.1	419.6	4	18±4
Жаргалтхаан	1820.8	285.3	9	57±8
Мөрөн	387.9	67.5	4	23±5
Норовлин	3050.8	265.5	8	92±10
Өмнөдэлгэр	7940.9	271.2	11	322±18
Цэнхэрмандал	1487.7	581.4	28	72±8
Нийт	40778.7	3546	145	2403±175

2017 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар **2403±175 толгой саарал чоно 1000 га-д 0.7 бодгаль** ногдох нягтшилтай байна.

Иймээс чоныг зөвхөн сөрөг нүдээр харах биш, бас түүний орчин зүйд (экологи) үзүүлэх эерэг ач холбогдол, бусад холбогдлын талаар орон нутагт сурталчлах ажлыг зохион байгуулах хэрэгтэй байна.

Шар үнэгний тархац, байршил, тоо толгой.

Бүс нутгийн тархац. Хэнтий аймгийн бүх сумдын нутагт өргөн тархах боловч өнөө үед тус аймгийн шар үнэгний тоо толгой цөлөрхөг хээрээр багасаж тус сумын хойт хэсэг болох ой болон уулархаг нуруудын салбар уулсаар элбэг.

Тоо толгой, нягтшил, нөөцийн үнэлгээ. 2002 оны агнуур зохион байгуулалтаар 11550 км² нутагт 357 тоо толгой. 2012 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар 42000 км² нутагт 1000 га-д 0.39 бодгаль ноогдох нягтшилтайгаар 1638±58 толгой шар үнэг тархан байршиж байна.

Хүснэгт 9. Шар үнэгний нөөцийн үнэлгээ

Сумын нэр	Байршил нутаг (км2)	Сорилын талбай (км2) /Ssd/	Ажиглагдсан бодгаль /Ns/	Нийт нөөц /Nt/	Агнуурын нөөц
Батноров	3222.4	67	5	240±16	48
Батшрээт	5011.7	69.2	6	435±21	87
Баян-Адрага	1989.9	71.4	8	223±15	45
Баянхутаг	1226.1	19	2	129±11	26
Баянмөнх	90.9	1.9	3	144±12	29
Баян-Овоо	290.7	4	1	73±9	15
Биндэр	3222.3	35	4	368±19	74
Дадал	2470.8	27	3	275±17	55
Дархан	94.7	1	1	95±10	19
Дэлгэрхаан	1774.6	18	2	197±14	39
Галшар	704.2	8.7	3	243±16	49
Хэрлэн	1273.7	71	1	18±4	4
Жаргалтхаан	1301.3	65	6	120±11	24
Мөрөн	235.0	6.5	2	72±9	14
Норовлин	1949.9	55	7	248±16	50
Өмнөдэлгэр	5100.7	137	9	335±18	67
Цэнхэрмандал	790.3	41	7	135±12	27
Нийт	30749.1	697.7	70.0	3349±147	669

2017 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар **30749.1 км² нутагт 3349±147 толгой шар үнэг 1000 га-д 0.7 бодгаль** ногдох нягтшилтай байна.

Хярс үнэгний тархац, байршил, тоо толгой.

Хамгааллын статус: “Амьтны тухай” хуулиар ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар хярс агнахыг 10-р сарын 21-ээс 2-р сарын 16-ийг хүртэл зөвшөөрөгдсөн байдаг. ДБХХ хярс үнэгийг анхааралд авах шаардлагагүй зүйлийн ангилалд оруулжээ. СITES-д ямар нэгэн тусгай ангилалд ороогүй байна. Монгол орны хөхтөн амьтны улаан дансанд “ховордож болзошгүй” гэдэг ангиллаар үнэлсэн байдаг.

Бүс нутгийн тархац. Хэнтий аймгийн урд сумдын нутагт тархах боловч өнөө үед тус аймгийн хярс үнэгний тоо толгой голын хөндий, уудам тал, уулс хоорондын хөндий, хээр, цөлөрхөг хээрээр элбэг тохиолдоно. Хярс үнэгний тархац нутаг байршил үлийн цагаан отготны тоо толгойн өсөлт бууралттай ихээхэн хамааралтай байдаг. Хаана үлийн цагаан отготны голомт нутаг байна тэнд хярс үнэгний нягтшил өндөр байдаг.

Тоо толгой, нягтшил, нөөцийн үнэлгээ. 2002 оны агнуур зохион байгуулалтаар 8146 км² нутаг 461 тоо толгой. 2012 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар 42000 км² нутагт 1000 га-д 0.43 бодгаль ноогдох нягтшилтайгаар 1806±89 толгой хярс үнэг тоологдсон байна.

Хүснэгт 10. Хярс үнэгний нөөцийн үнэлгээ

Сумын нэр	Байршил нутаг (км ²)	Сорилын талбай (км ²) /Ssd/	Ажиглагдсан бодгаль /Ns/	Нийт нөөц /Nt/	Агнуурын нөөц
Батноров	1241.5	77	7	113±11	23
Батшрээт	549.4	175	6	19±4	4
Баян-Адрага	629.8	63	9	90±9	18
Баянхутаг	1436.8	82	2	35±6	7
Баянмөнх	1461.7	72	1	20±5	4
Баян-Овоо	1222.9	58	3	63±8	13
Биндэр	864.2	55		0±0	
Дадал	758.3	48		0±0	
Дархан	567.0	75	5	38±6	8
Дэлгэрхаан	1230.4	158	12	93±10	19
Галшар	840.5	35	3	72±8	14
Хэрлэн	1528.4	101		0±0	
Жаргалтхаан	887.1	145	6	37±6	7
Мөрөн	1087.7	137	2	16±4	3
Норовлин	1172.0	133	13	115±11	23
Өмнөдэлгэр	1239.2	157	10	79±9	16
Цэнхэрмандал	216.0	23	8	75±9	15
Нийт	16933.0	1594.0	87.0	924±30	185

2017 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар бүх сумдын нутгийг хамарсан аймгийн нийт нутгийн 20,4 хувийг эзлэх **16933.0 км² нутагт 924±30 толгой хярс үнэг 1000 га-д 0.5 бодгаль** ноогдох нягтшилтай байна.

Халздай доргоны (*Meles meles*) Тоо толгой, нягтшил, нөөцийн үнэлгээ. 2012 оны ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгаагаар 2050 толгой халздай дорготойг тогтоосон байна. 2017 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар **17384.0 км² нутагт 1341±136 толгой халздай дорго 1000 га-д 0.7 бодгаль** ногдох нягтшилтай байна.

Нохой зээхийн (*Gulo gulo*) Тоо толгой, нягтшил, нөөцийн үнэлгээ. 2002 оны агнуур зохион байгуулалтаар 5539 км² нутагт 27 тоо толгой. 2012 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар аймгийн ойт нутагт 155±8 нохой зээх тархан байршиж байх боломжтойг тогтоосон байна. 2017 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар **7024.5 км² нутагт 344±58 толгой нохой зээх 1000 га-д 0.4 бодгаль** ногдох нягтшилтай байна.

Чандага туулай (*Lepus timidus* Linnaeus, 1758) Тоо толгой, нягтшил, нөөцийн үнэлгээ. 2002 оны агнуур зохион байгуулалтаар 11917 км² нутагт 1340 тоо толгой. 2012 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар Хэнтий аймгийн нутагт 12570±627 толгой чандага туулай тархан байршиж байжээ. 2017 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар **5644.1 км² нутагт 1046±132 толгой чандага туулай 1000 га-д 1.8 бодгаль** ногдох нягтшилтай байна.

2017 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар 7163.4 км² нутагт 190±13 толгой молцог хандгай, 6556.9 км² нутагт 143±11 толгой баданга хүдэр, Дадал, Биндэр, Батширээт, Өмнөдэлгэр сумдын 5477.6 км² нутагт 132±7 толгой хүрэн баавгай, 10244.5 км² нутагт 29923±4172 толгой бор туулай байна.

Хэнтий аймгийн агнуурын шувууны төрөл зүйлийн бүрдэл, нөөцийн тухай.

Хэнтий аймгийн агнуурын шувуудыг ангилал зүйн үүднээс авч үзвэл Монгол орны шувууны аймгийн 9 багт орох 11 овгийн 27 төрлийн 43 зүйл шувуу байна (Хэнтий аймгийн нутагт тархсан нийт зүйл шувууны жагсаалтыг тусгайлан хавсралт хүснэгт 1-ээс үз). Баг тус бүрээр нь авч үзвэл ахуунтны 1 зүйл, шунгууртны 1 зүйл, хотонтоны 1 зүйл, өрвитөний 1 зүйл, галуутаны 19 зүйл, тахиатаны 5 зүйл, тогоруутаны 4 зүйл, хөгчүүтэний 6 зүйл, тагтаатаны 5 зүйл тус тус байна. Хэнтий агнуурын шувуудаас 7 зүйл нь суурин шувуу (хар хур, нургийн сойр, эрэн хавирга хахилаг, дагуур ятуу, монгол ногтруу, хөхвөр тагтаа, хадны тагтаа) бусад 35 зүйл нь нүүдлийн шувуу байна. Тэдгээрийг оршин байх хэлбэрээр нь авч үзвэл үүрлэж өндөглөдөг 39 зүйл буюу Хэнтий аймгийн нийт агнуурын

шувууны 90% байгаа нь тус аймагт агнуурын шувуу тархсан нутаг нь амьдрах, тэр дотроо үүр засаж өндөглөх таатай нөхцөлөөр арвин байгааг харуулна. Хэнтий аймгийн агнуурын шувууны нөөцийн хувьд шувуу бүр дээр харилцан адилгүй. Тэнд тохиолдох 43 зүйл агнуурын ач холбогдолтой шувууны 8 зүйл элбэг (хондон ангир, эрээн хавирга хахилаг, дагуур ятуу, улаан хөлт хөгчүү, мөнгөлөг цахлай, монгол ногтруу, хадны тагтаа), 22 зүйл ердийн, 13 зүйл ховор буюу ховордуу байна.

Хамгийн олон шувууг Өмнөдэлгэр (865 ширхэг), Батширээт (1050 ширхэг), Биндэр (1020 ширхэг), Баян-Адрага сум (840 ширхэг), Дадал сум (670 ширхэг) сумууд бэлтгэх ба хамгийн цөөнийг Хэрлэн сум (75 ширхэг) агнахаар харагдаж байна. Дээрх шувуудын 1310 толгой дагуур ятуу, 1010 монгол ногтруу, 440 хондон ангир, 410 анхитал ангир, 290 хар хур, 220 нургийн сойроос бүрдэж байгаа нь тэр нутгийн агнуурын шувуу хөлдүү түүхий эдийн чиглэлтэй, агнуурын өндөр ач холбогдолтой болохыг харуулна. Хэнтий аймагт явуулсан судалгаанаас харахад нийтдээ 8094 ширхэг агнуурын хөлдүү түүхий эдийн ба усны шувуу бэлтгэх боломжтой.

Ан амьтны амьдрах орчны үнэлгээ

Агнуурын бүс нутгийг сонгохдоо гол төлөв матрицын аргыг ашиглан бүс нутгийн бэлчээрийн нөхцөл, усан хангамж, байгалийн нөлөө, амьдрах орчин, хүний нөлөө, агнуурын нөөц зэрэг хүчин зүйлийг харгалзан “сайн”, “дунд”, “муу” гэсэн үнэлгээгээр сонгон авдаг туршлага бий. Түүнчлэн өмнө нь тусгай зориулалт болон ахуйн зорилгоор зөвшөөрөл олгогдож, одоо хүртэл агнуур эрхэлж байсан, орон нутгийн удирдлага агнуурын бүс нутаг байгуулах боломжтой гэж санал өгч байгаа, тусгай зөвшөөрлөөр агнагддаг зүйлүүд агнуурын тодорхой нөөцтэй, орон нутгийн иргэд тэдний оролцоонд тулгуурласан агнуурын менежментийг хэрэгжүүлэх нөхцөлд хамтран оролцож үр шимийг нь хүртэх, хамгаалалтын ажилд идэвхтэй оролцох сонирхолтой, агнуурын бүс болгохоор санал болгож буй газрыг орон нутгийн хамгаалалтад авах боломжтой зэрэг нөхцөлүүдийг харгалзан үздэг.

Хэнтий аймгийн нутагт агнуурын бүс нутгийг сонгохдоо айл малын байршил, тоо толгой, ил задгай усны байршил гэх мэт зэрлэг хөхтөн амьтны элдэв хэлбэрт нөлөөлж болзошгүй нийгэм эдийн засгийн холбогдолтой мэдээлэлд анализ хийснээс гадна амьдрах

орчны загварчлалаар тодруулан гаргасан тухайн амьтдын тархац, байршлын цөм нутаг, тоо толгой, нөөцийн үнэлгээ зэрэг мэдээллийг ашиглав.

Сүүлийн жилүүдэд тус аймгийн малын тоо толгойн бодит өсөлтөөс шалтгаалан ховор болоод агнуурын амьтдын байршил нутагт бэлчээр талхлагдах үзэгдэл газар авч байна. Түүнчлэн тархац нутгийн зарим хэсэгт хууль бусаар алт олборлох үйл ажиллагаа мэр сэр явагдаж байгаа нь эдгээр амьтдын тархац байршилд сөргөөр нөлөөлөхгүй гэх үндэслэл алга юм.

Агнуурын ач холбогдолтой хөхтөн амьтдын популяцид ялангуяа цагаан зээр, монгол тарваганы тоо толгойд хууль бус ан агнуурын үйл ажиллагаа ихээхэн нөлөөтэй бөгөөд тэдгээрийн сүргийн бүтэц алдагдан, популяцийн нөхөн үржилд сөргөөр нөлөөлдөг байна.

ХОЁР. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО

2.1. Ан агнуурын менежментийн тухай ойлголт, хамгааллын менежментийн өнөөгийн байдал

Агнуурын зүйлүүдийг тогтвортой, популяцид хал багатайгаар, төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн иргэд, бүс нутгийг эзэмшиж буй нөхөрлөл, хуулийн этгээдийн эрх ашигт нийцүүлэн ашиглах төдийгүй орлогын багагүй хэсгийг ан амьтад, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалахад эргэж зарцуулдаг, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог агнуурын менежмент гэж үздэг.

Агнуурын менежментийг хэрэгжүүлэхэд тодорхой нөхцөлүүд хангагдсан байх шаардлагатай байдаг, тухайлбал:

- Агнуурын менежмент хэрэгжих нөхцөлийг хангахад чиглэсэн эрх зүйн орчин
- Менежментийг хэрэгжүүлэгчид нь мэргэжлийн төвшинд ажиллах мэдлэг, чадвар эзэмшиж чадавхажсан байх.
- Үйл ажиллагаандаа мониторинг тогтмол хийж үнэлж байх.
- Мэдээлэл ил тод байх.
- Ан амьтныг ашиглах арга хэрэгсэл нь боловсронгуй, хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн байх.
- Ан агнуурыг зөвхөн агнуурын бүс нутагт хэрэгжүүлэх.

Менежментийн гол зорилго нь агнуураас тогтвортой орлого олж байх явдал. Үүний тулд агнуурын зүйлүүдийн популяцийг мониторингийн хэлбэрээр байнга хянаж, мэдээ цуглуулж байх шаардлагатай. Энэ нь ашиглалтад өртөж буй зүйлүүдийн популяци эрүүл байгаа эсэхийг үнэлэх боломж олгоно. Мониторинг хийх нь давуу ба сул талуудтай.

Давуу тал:

- ❖ Популяци эрүүл эсэхийг үнэлэх боломжтой болно.
- ❖ Мэдээллийн сан шинэ мэдээгээр байнга баяжигдана.

Сул тал:

- ❖ Урт удаан хугацаа шаарддаг
- ❖ Зардал өндөр гардаг
- ❖ Хэрэглэж буй арга хэрэгслээ байнга хянаж орчин үеийн шаардлага, стандартуудад нийцүүлэн шинэчилж байх хэрэгтэй болдог

Одоогийн практикаас үзэхэд зөвшөөрөл олгогдсон газраа агнасан эсэх дээр ихээхэн маргаан гардаг учраас эзэмшиж буй агнуурын бүс нутгаа тойруулан тэмдэг тавих хэрэгтэй юм. Хэдийгээр агнуурын бүс нутгийг хариуцан түүндээ ан хийх эрхтэй боловч Монгол улсын хуульд зааснаар “ан амьтан нь улсын өмч” юм. Иймд агнуурын бүс нутагтаа зарим амьтдыг төрөөс худалдан авч гаршуулах хэрэгтэй ба ингэснээр үр төл нь менежментийг хэрэгжүүлэгчийн өмч болох боломжтой болдог. Энэ нь тогтвортой хөгжлийн үндэс болно.

2.2. Менежментийн төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчмууд

Өмнө нь зөвхөн улсын тусгай хамгаалалттай газрууд, тэдгээрийн орчны бүсүүдийг хамарсан нутаг дэвсгэрт менежментийн төлөвлөгөө боловсруулдаг байсан. Аймгийн төвшинд ан агнуурын менежментийн төлөвлөгөө бараг боловсрогдож байгаагүй. Монгол улсын засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 93 дугаар тогтоолын 1- дүгээр хавсралтын дагуу мөн шинэчлэгдэн өөрчлөгдсөн хууль, тогтоомжийг үндэс болгон Хэнтий аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулсан болно.

Бид энэхүү менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа аймгийн ан агнуурын харилцааг зохион байгуулж зохицуулах үндсэн үүргийг аймгийн БОАЖГ хүлээх ба оролцогч гол талууд нь агнуурын бүс нутгийг хариуцахаар гэрээлж авсан нөхөрлөлүүд, хуулийн этгээд байхаар санал болгов.

Энэхүү менежментийн төлөвлөгөөний зарим үйл ажиллагаанууд нь аймгийн хилийн заагаар хязгаарлагдахгүй. Учир нь агнуурын амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөн нь хүмүүсийн гаргасан аливаа хил хязгаарт хашигдахгүй. Мөн бэлчээр болон байгалийн бусад баялгийг ашиглах төлөвлөлттэй уялдуулах, зохицуулах шаардлага гардаг. Иймд энэхүү менежментийн төлөвлөгөө нь байнга баяжигдан өөрчлөгдөж байх уян хатан байх ёстой гэсэн зарчим баримталж байна.

Аймгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа дараах шаардлагуудыг мөрдлөг болгов. Үүнд:

- Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлага, иргэдийн **оролцоог хангахуйц бүтэц, зохион байгуулалтын механизмыг** бүрдүүлэх хэрэгцээ шаардлагыг хангах,
- Учирч буй бэрхшээл, түүнийг үүсгэж байгаа шалтгааныг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаануудыг менежментийн төлөвлөгөөнд **бүрэн тусган** хэрэгжүүлэх,
- Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа шийдвэр, хэрэгжүүлэх үйл явц, хяналт нь **талуудын идэвхтэй оролцоог хангасан** байх,
- Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтаар төлөвлөгөөний дагуу хангах,
- Менежментийн төлөвлөгөө нь тасралтгүй явагдах үйл явц тул тухайн үеийн шаардлага, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгож өөрчлөлт оруулж байх,
- Улс төр, эдийн засгийн нөхцөл болон **удирдлагын хувийн сонирхлоос үл хамааран** хэрэгждэг байх

2.3. Менежментийн төлөвлөгөөний онцлог, ач холбогдол

Энэ менежментийн төлөвлөгөө нь орон нутгийн төр, захиргааны байгууллага, ТББ, нөхөрлөлүүд, тухайн хуулийн этгээд зэрэг талуудын оролцоог хангаснаараа онцлог болсон болно.

Энэхүү менежментийн төлөвлөгөө нь Монгол улсын Засгийн газар, БОАЖЯ-наас ан агнуурын талаар баримталж буй бодлогыг үндэс болгон ан амьтны байршил нутаг, улмаар агнуурын бүс нутгийн хамгаалалтын үйл ажиллагаанд нутгийн иргэдийг тогтмол,

идэвхтэй оролцуулах, хамтын ажиллагааг бүх шатанд хөгжүүлэх мөрийн хөтөлбөр болж буйгаараа ач холбогдолтой юм. Менежментийн төлөвлөгөөтэй болсноор аймгаас агнуурын талаар явуулах үйл ажиллагааны бодлого, чиглэл, хүрэх үр дүн тодорхой болсон байна.

Менежментийн төлөвлөгөө хэрэгжсэнээр:

- Агнуурын бүс нутгууд шинээр байгуулагдаж баталгаажна,
- Хамтран ажиллагч талууд идэвхжих, чадавхжих,
- Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, явц, үр дүнг ил тод мэдээлэх тогтолцоо бүрдэх,
- Аймгийн агнуурын сангийн үнэ цэнэ нэмэгдэж агнуурын бүс нутгийг хариуцан хамгаалж буй нөхөрлөлийн гишүүд, нутгийн иргэдийн амьдралын нөхцөл сайжрах,
- Агнуурын бүсийг хариуцаж буй нөхөрлөлүүд, хуулийн этгээд “өөрсдөө агнуурын бүс нутаг дахь ан амьтдаа хамгаалах, зохистой ашиглах үйл явцыг удирдан зохион байгуулах чадвартай” гэдгээ ойлгон итгэлтэй болох,
- Ан амьтдын популяцийн хэвийн амьдрах нөхцөл бүрэлдэж хүний хүчин зүйлийн сөрөг нөлөөлөл буурах,
- Агнуурын санг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах үйл ажиллагаа нэг нь нөгөөгөө нөхөж салшгүй уялдаа холбоотой хийгддэг болох зэрэг олон талын ач холбогдолтой болно.

ГУРАВ. МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, СТРАТЕГИ

3.1. Алсын хараа, эрхэм зорилго

Энэхүү менежментийн төлөвлөгөөний зорилго нь Хэнтий аймгийн ховор болоод агнуурын амьтанд учирч байгаа болон болзошгүй аюул дарамтыг арилгах, багасгах арга замыг тодорхойлох, нөхөн сэргээгдэх байгалийн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах менежментийг бүрдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд, хувийн хэвшил, мэргэжлийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар байгалийн нөөцийн хамтын менежментийг бий болгоход оршино.

3.2. Хамрах хүрээ

Хэнтий аймгийн ан агнуурын 2017-2022 онд хэрэгжих энэхүү менежментийн төлөвлөгөөнд байгалийн бүс, бүслүүрийн онцлог, ховор болон агнуурын ач холбогдолтой ан амьтдын популяцийн хувьсан өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, зохистой ашиглах, хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаануудыг талуудын оролцоотойгоор хэрэгжүүлэхээр тусгалаа.

Хэнтий аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцогч талууд

- Агнуурын бүс нутгийг менежментээр хариуцагч нутгийн иргэд, идэвхтэн байгаль хамгаалагчид
- Аймгийн БОАЖГ, ЗДТГ,
- Сумын ИТХ тэргүүлэгчид
- Байгаль орчны мэргэжлийн байгууллага

Хэнтий аймгийн экосистемийг төлөөлж чадахуйц амьтан, ургамлын зүйл, бүлгэмдэл, экосистемийг сонгов. Үүнд:

I. Хамгаалахаар сонгосон экологийн систем

- ❖ Цөлөрхөг хээрийн экосистем

II. Хамгаалахаар сонгосон амьтан, ургамал

- ❖ Аргаль хонь (*Ovis ammon*)
- ❖ Цагаан зээр (*Procapra gutturosa*)
- ❖ Халиун буга (*cervus elaphus*)
- ❖ Бор гөрөөс (*Capreolus pygargus*)
- ❖ Зэрлэг гахай (*Sus scrofa*)
- ❖ Монгол тарвага (*Marmota sibirica*)

Экосистемийн төлөөлөл болгож сонгосон эдгээр 6 амьтан, экосистемд түшиглэж Хэнтий аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

3.3. Ховор болон агнуурын ач холбогдолтой хөхтөн амьтны амьдрах орчин, экосистем тэдгээрийн өнөөгийн байдал амьдрах чадварын үнэлгээ

Хамгаалахаар сонгосон газрын экосистемийн төлөөлөл болох биологийн олон янз байдал буюу амьтан, ургамал, бүлгэмдэл экосистемийн экологийн түлхүүр шинж чанарыг тодорхойлов.

Сонгож авсан биологийн олон янз байдал нь амьдралын түүхэнд нь хамгийн ихээр нөлөөлдөг биологийн процесс, бүрдэл, бүтэц, тархац зэрэг шинж чанар дээр тулгуурлан үнэлгээ өгсөн. Экологийн гол түлхүүр шинжийг хэмжээ, нөхцөл, ландшафт гэсэн 3 категориор муу, дунд зэрэг, сайн, маш сайн гэсэн үнэлгээг тодорхойлж өнөөгийн байдал нь эдгээр үнэлгээний алинд тохирч байгаа, 5 жилийн дараа гэхэд эдгээр үнэлгээний алинд нь хүргэх зорилттой байгааг тодорхойлсон.

Тайлбар

- Багана 1: Биологийн төрөл зүйл** / Экосистемийн төлөөлөл болгож сонгосон амьтан, ургамал, бүлгэмдэл, экосистем
- Багана 2:Экологийн түлхүүр шинж** / Тухайн категорид дүйцсэн амьтан, ургамал, бүлгэмдэл, экосистемийн оршин тогтож нөхөн ургах гол шинж тэмдэг
- Багана 3:Үнэлгээ** / Экологийн шинж тэмдгийн илэрхийллийг тоон хэмжээгээр үнэлсэн байдал
- Багана 4: Экологийн шинж тэмдгийн одоогийн илтгүүрийн тодорхойлолт**/ Одоогийн байдлыг хэрхэн үнэлж байгаа тодорхойлолт
- Багана 5:Одоогийн байдал**/ Экологийн шинж тэмдгийн илэрхийлэлийг тоон хэмжээгээр үнэлсэн байдлаас одоогийн байдалд аль үнэлгээ нь таарсныг сонгосон байдал
- Багана 6: Зорилт** / Экологийн шинж тэмдгийн илэрхийллийг тоон хэмжээгээр үнэлсэн байдлаас одоогийн байдлыг хэрхэн өөрчилж аль хэмжээнд хүргэх гэж хүсэн хүлээж байгаагаа үр дүн

Хүснэгт -11.Экосистемийн төлөөлөл болох биологийн олон янз байдлын экологийн түлхүүр шинж чанарыг тодорхойлсон байдал

1	2	3				4	5	6
Биологийн төрөл зүйл	Экологийн түлхүүр шинж	Муу	Дунд	Сайн	Маш сайн	Одоогийн илтгүүрийн тодорхойлолт	Өнөөгийн байдал	Зорилт
Аргаль хонь	тархац нутаг км ²	>500	1000-2000%	2500-3000	3500<	1552 км ²	Дунд	Тархац нутаг, тоо толгойг 20 хувиар нэмэгдүүлсэн байна.
	Тоо толгой	>300	450-550	650-750	800<	505	Дунд	
Цагаан зээр	тархац нутаг км ²	>15000	20000-25000	30000-40000	50000<	20860 км ²	Дунд	
	Тоо толгой	>10000	15000-20000	25000-35000	40000<	31338	Сайн	

1	2	3				4	5	6
Биологийн төрөл зүйл	Экологийн түлхүүр шинж	Муу	Дунд	Сайн	Маш сайн	Одоогийн илтгүүрийн тодорхойлолт	Өнөөгийн байдал	Зорилт
Халиун буга	тархац нутаг км ²	>2000	2500-4500	6500-11000	15000<	2692 км ²	Дунд	
	Тоо толгой	>1000	1500-2000	2500-3500	5000<	3079	Сайн	
Бор гөрөөс	тархац нутаг км ²	>5000	6000-10000	1300-17000	20000<	6536 км ²	Дунд	
	Тоо толгой	>1000	2000-4000	6000-8000	9000<	3398	Дунд	
Зэрлэг гахай	тархац нутаг км ²	>1500	2000-5000	7000-9000	12000<	2162 км ²	Дунд	
	Тоо толгой	>1000	1500-2500	3500-4500	7000<	1757	Дунд	
Монгол тарвага	тархац нутаг км ²	>700	1000-2000	3000-6000	8000<	1034 км ²	Дунд	
	Тоо толгой	>4000	5500-7500	8500-9500	12000<	7204	Дунд	
Цөлөрхөг хээрийн экосистем	Уур амьсгалын өөрчлөлт						Мэдээлэл хэрэгтэй	
	Цөлжилт	-	-	-	-		Мэдээлэл хэрэгтэй	

3.4. Хамгаалахаар сонгосон амьтны зүйл, тэдгээрийн амьдрах орчин, идэш тэжээлийн бүлгэмдэл,экосистемд учирч буй аюул дарамтын үнэлгээ

Хүснэгт 12

Биологийн олон янз байдлын экологийн түлхүүрт шинжид учирч байгаа аюулж.		Аргаль хонь	Монгол тарвага	Цагаан зээр	Халиун буга	Бор гөрөөс	Зэрлэг гахай	Цөлөрхөг хээр
		1	2	3				4
1	Амьдрах орчны доройтол	Дунд	Их	Их	Их	Их	Их	-
2	Амьдрах орчны шахагдтал	Их	Их	Их	Их	Их	Их	-
3	Махчин амьтны нөлөөлөл	Их	Их	Их	Их	Их	Их	-
4	Тоо толгой бууралт	Их	Их	Их	Их	Их	Их	-
5	Уур амьсгалын өөрчлөлт	Их	Их	Их	Их	Их	Их	Дунд
6	Ган, зуд	Их	Их	Их	Их	Их	Их	Дунд
7	Бэлчээрийн давхцал, доройтол	Их	Их	Их	Их	Их	Их	Дунд

Хүснэгт 13. Аюулыг бий болгож байгаа эх үүсвэрүүд

Аюулыг бий болгож байгаа эх үүсвэр		Аргаль хонь	Цагаан зээр	Монгол тарвага	Халиун буга	Бор гөрөөс	Зэрлэг гахай	Цөлөрхөг хээр	Дарамтын ерөнхий үнэлгээ
		1	2	3	4	5		6	
1	Хууль бус агнуур	Бага	Их	Их	Дунд	Их	Их	-	Их
2	Уул уурхай	Их	Дунд	Дунд	Дунд	Дунд	Дунд	Дунд	Дунд
3	Агнуурын зохистой менежментгүй болсон	Бага	Их	Их	Дунд	Их	Их	-	Их
4	Бэлчээрийн давхцал, доройтол	Их	Их	Их	Их	Их	Их	Их	Их
5	Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө	Их	Их	Их	Их	Их	Их	Их	Их
7	Ган, зуд	Их	Их	Их	Их	Их	Их	Их	Их
Threat Status for Targets and Project		Их	Их	Их	Дунд	Их		Их	Их

3.5. Ан агнуурын менежментийн төлөвлөгөөний зорилт

Төлөөлөл болгон хамгаалахаар сонгосон биологийн олон янз байдалд нөлөөлж буй дарамтад үнэлгээ өгч, тэдгээрийг үүсгэж байгаа шалтгаануудыг тодорхойлж (*Диаграмм 1*), дээрх үнэлгээг үндэслэн биологийн олон янз байдалд учирч буй дарамтын нөлөөг бууруулахад чиглэгдсэн доорх 4 стратегийн хүрээнд үйл ажиллагааг төлөвлөв.

Зорилго 1.Агнуурын зүйлүүдийг байгалийн нөхцөлд хэвийн өсөж үржих нөхцөлийг бүрдүүлэх

Зорилтууд:

1. Агнуурын зүйлүүдийн мониторингийг өргөжүүлэх, мониторингийг хэрэгжүүлэгчид, оролцогчдыг чадавхжуулах
2. Агнуурын бүс нутгийг шинээр байгуулах, үйл ажиллагааг нь тогтмолжуулах, нарийвчилсан агнуур зохион байгуулалт, менежментийн төлөвлөгөөг оролцооны аргаар хийж хэрэгжүүлэх
3. Агнуурын амьтдын байршлыг тогтворжуулах, нөхөн үржлийн хэвийн нөхцөлийг хангахад чиглэсэн цогц арга хэмжээг ан агнуурын менежментийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх
4. Мониторингийн судалгааны үр дүнг хамгаалалтын менежментийн төлөвлөгөөний үндэслэл болгох
5. Мэдээллийн санг бүрдүүлэх

Хүрсэн байх үр дүн: Мэдээллийн сан бүрдэж, агнуурын бүс нутаг үнэлэгдэн, бүс нутгийг (бэлчээрийг) бусад ашиглагчидтай зохицон ашиглах менежменттэй болж, судалгааны мониторинг тогтмолжин, үр дүнг нь хамгаалалтын менежментийг сайжруулахад хэрэглэдэг болж, хэрэгжүүлэгчид нь чадавхажсан байна.

Зорилго 2. Оролцоог хангасан удирдлага, зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох

Зорилтууд:

1. Удирдлага, зохион байгуулалтын бүтцийг чадавхжуулах,
2. Хяналт шалгалт, хамгаалалтын ажлыг сайжруулах,
3. Хамтын ажиллагааг бүх шатанд өргөжүүлэх,

Хүрсэн байх үр дүн: Удирдлага, зохион байгуулалтын бүтэц чадавхжин, хяналт шалгалт, хамгаалалтын ажлын чанар нь сайжирч, хамтын ажиллагаа бүх шатанд өргөжсөн байна.

Зорилго 3. Санхүүгийн тогтвортой эх үүсвэрийг бий болгох

Зорилтууд:

1. Хамгаалалт, хяналт мониторинг, сурталчилгаатай холбоотой зардлыг төлөвлөн аймгийн төсвөөс тогтвортой санхүүжүүлдэг байх
2. Агнуурын бүс нутгуудад бизнес төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэх
3. Хариуцлагатай байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх

Хүрсэн байх үр дүн: Хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр баталгаатай болсон байна.

Зорилго 4. Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол үнэлэх мониторингийн тогтолцоог бүрдүүлэх

Зорилт:

1. Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянан үнэлэх тогтолцоог бүрдүүлэх

Хүрсэн байх үр дүн: Энэ тогтолцоо нь уг төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэх хэрэглүүр болсон байна.

3.6. Хэнтий аймагт 2017-2022 онуудад хэрэгжүүлэх ан агнуурын менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Хүснэгт 14

Зорилт	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцагч	Төсөв (сая.төг)	Зорилтын хэрэгжилтийн шалгуур
Зорилго 1. Агнуурын зүйлүүдийг байгалийн нөхцөлд хэвийн өсөж үржих нөхцөлийг бүрдүүлэх					
1.1 Агнуурын зүйлүүдийн мониторингийг өргөжүүлэх, оролцогчдыг чадавхжуулах	1.1.1. Аймгийн ИТХТ-аар “Аймгийн агнуурын менежментийн төлөвлөгөө”-г батлуулах	2017	Аймгийн БОАЖГ “Эко-үйлчилгээ” ТББ ШУА-ийн холбогдох хүрээлэнгүүд	0	-Аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө батлагдсан байна.
	1.1.2. “Агнуурын бүс” нутгуудын байршил, хилийн цэс”-ийг дахин нягталж сайжруулан батлах	2017-2018		2	
	1.1.3. Агнуурын байршил болон бүс нутгуудад хийх мониторингийн маршрутыг шинээр тогтоох	2017-2018		2	
	1.1.4. Агнуурын байршил нутгуудад хийх судалгааны хэрэгцээг тодорхойлох	2017-2018		1	
	1.1.5. Судалгааг хэрэгжүүлэгчдийн тогтвортой ажиллах нөхцөлийг баталгаажуулах (агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллага, нөхөрлөлийн гишүүдтэй тогтвортой ажиллагааны гэрээ хийх)	2018		0	-Агнуурын байршил болон бүс нутгуудад хийх мониторингийн судалгааны маршрут тогтоогдсон байна
	1.1.6. Хэрэгцээг үндэслэн мониторингийн судалгааны чиглэл бүрээр төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, үүнд:	2017-2022		2	
	1.1.6.1 Агнуурын зүйлүүдийн мониторингийн судалгааг тогтмолжуулах	2017-2022		2	
	1.1.6.2. Бэлчээрийн нөөц, даацын судалгааг уулын болон тал хээрийн туруутны байршил нутагт хийх	2018 оноос		5	
	1.1.6.3. Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд амьтны тэжээлийн хэрэгцээг тооцох аргачлалыг боловсруулах	2018-2019		1	
	1.6.4. Мониторинг судалгааны болон агнуур зохион байгуулалтын үр дүнг ашиглан агнуурын нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглалтыг хэрэгжүүлэх	2017 оноос			

	1.1.7. Байгаль хамгаалагчид, нөхөрлөл, бүлгүүдийн гишүүдийг амьтан, ургамлын зүйлийн мониторинг, судалгааны анхан шатны мэдээ цуглуулах арга зүйд сургах, хамруулах	2017, 2018	“Эко-үйлчилгээ” ТББ	3	Байгаль хамгаалагчид, нөхөрлөлүүдийн гишүүд мониторингийн анхан шатны мэдэгдэхүүнтэй болсон байна.
	1.1.8. Мониторинг хэрэгжүүлэхэд шаардлагатай техник, багаж хэрэгсэл, урсгал зардлаар хангах, чанарыг нь сайжруулах	2017-2022		1	
			Аймгийн БОАЖГ		Мониторинг хийхэд шаардлагатай багаж хэрэглэлээр хангагдсан байна
1.2. Агнуурын бүс нутгийг шинээр байгуулах, үйл ажиллагааг нь тогтмолжуулах, нарийвчилсан агнуур зохион байгуулалт, менежментийн төлөвлөгөөг оролцооны аргаар хийж хэрэгжүүлэх	1.2.1. Агнуур зохион байгуулалтын тайланд санал болгосон агнуурын бүс нутгийн үндэслэлийг боловсруулах	2017	Аймгийн БОАЖГ “Эко-үйлчилгээ” ТББ	3	Агнуурын бүс нутгууд байгуулагдан нөхөрлөлүүдэд хариуцуулагдсан байна. Агнуурын бүсийг ОНХГ болгон баталгаажуулснаар лицензийн талбайд орох гэх мэт эрсдэлээс хамгаалах арга хэмжээг авсан байна.
	1.2.2. Агнуурын бүс нутгийн байршил, хилийн цэсийг батлуулах	2017	Аймгийн БОАЖГ	1	
	1.2.3. Агнуурын бүс нутгийг нөхөрлөл, хуулийн этгээд, байгууллага, иргэдэд хариуцуулан эзэмшүүлэх	2017		2	
	1.2.4. Монгол тарвага, Агнуурын шувууд, Цагаан зээр агнуурын бүс нутгуудад нарийвчилсан агнуур зохион байгуулалт хийлгэх	2018		19,4	
	1.1.7. Аргаль хонь, цагаан зээр, ойн туруутан, монгол тарваганы тархац, байршил бүхий зарим газрыг ОНХГ болгон эрсдэлээс сэргийлэхэд нь туслах	2018 оноос		2	
	1.1.8. Агнуурын бүс нутгийг үйл ажиллагааг удирдлагаар ханган тогтвортой ажиллуулах	2018 оноос		2	
1.3. Агнуурын амьтдын байршлыг тогтворжуулах, нөхөн үржлийн хэвийн нөхцөлийг хангахад чиглэсэн цогц арга хэмжээг	1.3.1. Агнуурын бүс нутгуудад ан амьтдын нөөцийн үнэлгээг төлөөлөл болгон сонгосон зүйлүүд дээр жил бүр хийх (аргаль хонь, цагаан зээр, ойн туруутан, монгол тарвага зэрэг)	2018 оноос	Аймгийн БОАЖГ ШУА-ийн Биологийн хүрээлэн Хөхтний экологийн лаборатори “Эко-үйлчилгээ” ТББ	5	Ан амьтдын нөөц 2017 оныхоос буураагүй байх.
	1.3.2. Агнуурын бүс нутагт биотехникийн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	2017 оноос	Аймгийн БОАЖГ	5	Тордох (биотехникийн) арга хэмжээ үр нөлөөтэй

хэрэгжүүлэх	1.3.3. Агнуурын зүйлүүдийн популяцид хүний нөлөөг багасгах арга хэмжээнүүдийг төлөвлөж хэрэгжүүлэх(бэлчээрийн давхцал, уурхайн улмаас зам хаагдах асуудал, хууль бус ан гм)	2018 оноос	Аймгийн БОАЖГ	2	хэрэгжсэн байх	
	1.3.4.Аргаль хонь, цагаан зээр, ойн туруутан зэргийн үржих, төллөх, үр төлөө өсгөх байршил нутгуудад хяналтыг эрчимжүүлэх	2017 оноос	Аймгийн БОАЖГ	3		
1.4 Мониторингийн судалгааны үр дүнг хамгаалалтын менежментэд хэрэглэх, сурталчлах	1.4.1. Өнөөг хүртэл хийж ирсэн судалгаа, үр дүнгийн талаарх мэдээллийг нэгтгэн бүртгэх	2017 оноос	Аймгийн БОАЖГ	1	Аймгийн БОАЖГ болон ИТХ танилцуулах	
	1.4.2. Судалгаа, мониторингийн үр дүнгээр тайлан бичих	2018		2		
	1.4.3. Эрх зүйн орчныг сайжруулахтай холбоотой саналуудыг уламжлан шийдвэрлүүлэх			2017 оноос	0	
	1.5. Мэдээллийн санг бүрдүүлэх	1.5.1. Ан амьтны сан, агнууртай холбоотой мэдээллийг байршуулан хадгалах, шаардлагатай тоног төхөөрөмж, программаар хангах, мэдээллийн цахим сангийн дизайн гаргах,	2017 оноос	Аймгийн БОАЖГ “Эко-үйлчилгээ” ТББ	5	Мэдээллийн сан нь цахим болон уламжлалт хэлбэрээр бүрдэх эхлэл тавигдсан.
1.5.2. Мэдээллийг бүрдүүлэх		2017 оноос	3			
Зардлын дүн				79.4		
Зорилго 2. Оролцоог хангасан удирдлага, зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох						
2.1 Удирдлага зохион байгуулалтын бүтцийг чадавхжуулах	2.1.2. Удирдлага, хэрэгжүүлэгчдийн бүтцийг чадавхжуулах ажлыг хэрэгжүүлэх (сургалт, багаж хэрэглэлийн хангалт)	2017 оноос	Аймгийн БОАЖГ	8	Удирдлагын бүтэц ба хэрэгжүүлэгчид туршлагажсан байна.	
	2.1.3. Агнуурын нөөцийн хамтын менежментийн аргыг нэвтрүүлж буй туршлагуудтай танилцах	8оноос		1		
2.2 Хяналт шалгалт, хамгаалалтын	2.2.1. Нөхөрлөлүүдийн төлөөллүүд, идэвхтэн байгаль хамгаалагчдаас сонгон оролцуулсан хяналт, шалгалтын баг бүрдүүлэх	2017 оноос	Аймгийн БОАЖГ	2	Хяналтын оролцоонд тулгуурласан тогтолцоо бий болсон	

ажлыг сайжруулах	2.2.2. Хяналтын багийн гишүүдэд байгаль хамгаалагчийн эрх, үнэмлэх олгуулах	2017 оноос		1	байна.
	2.2.3. Хяналт, шалгалтын үр дүнг тогтмол мэдээлж байх	2017 оноос		1	
2.3 Хамтын ажиллагааг бүх шатанд өргөжүүлэх	2.4.1. ТББ, бусад нөхөрлөлүүдтэй ажиллах чиглэлээ тогтоон гэрээ байгуулж ажиллах	2017 оноос	Аймгийн БОАЖГ	0	Хамтын ажиллагаа өргөжсөн байна.
	2.4.2. Судалгаа, сургалт, агнуур зохион байгуулалтын байгууллагуудтай ажиллах чиглэлээ тогтоон гэрээ байгуулж ажиллах	2017 оноос		4	
	2.4.3. Нөхөрлөлийн гишүүдээс байгаль орчны мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэх	2017 оноос		3	
Зардлын дүн				20	
Зорилго 3. Санхүүгийн тогтвортой эх үүсвэрийг бий болгох					
3.1. “Хэнтий аймгийн ан амьтад” итгэлцлийн санг байгуулах	3.1.1. “Хэнтий аймгийн ан амьтад” итгэмжлэх санг байгуулах үндэслэл, санг бүрдүүлэх, захиран зарцуулах, сангийн үйл ажиллагааг хянан үнэлэх журмыг боловсруулан батлуулах	2017 оноос	Аймгийн БОАЖГ	2	Сан байгуулагдаж, хуримтлал бий болсон. Орон нутгийн бүлэг нөхөрлөл хариуцлагатай, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чадавхажсан байна.
	3.1.2 Санг байгуулах, бүртгүүлэх ажлыг зохион байгуулах	2017 оноос		1	
	3.1.3 Санд хуримтлал бүрдүүлэх	2017 оноос		5	
	3.1.4. Хариуцлагатай, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэн, малчдын бүлэг нөхөрлөлийн оролцоог хангах	2017 оноос		4	
3.2. Хамгаалалт, хяналт, мониторинг, сурталчилгаатай холбоотой зардлыг төлөвлөн аймгийн төсвөөс тогтвортой санхүүжүүлдэг байх	3.2.1. Хамгаалалт, хяналт шалгалттай холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан гарган батлуулах	Жил бүр	Аймгийн БОАЖГ “Эко-үйлчилгээ ” ТББ	2	Төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн баталгаа бий болсон байх Хуулийн хугацаанд ерөнхий АЗБ хийгдсэн байх
	3.2.2. Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн тооцоог тодотгон боловсруулах	Жил бүр		1	
	3.2.3. Аймгийн түвшинд ерөнхий агнуурын зохион байгуулалтыг хуульд заасан хугацаанд хийлгэх	2022 онд		30	
Зардлын дүн				45	

**Зорилго 4. Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол үнэлэх
мониторингийн тогтолцоог бүрдүүлэх**

4.1. Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянан үнэлэх	Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж үнэлж байх	2017 оноос	Аймгийн БОАЖГ	5	Төлөвлөгдсөн үйл ажиллагаанууд хугацаандаа хэрэгжих нөхцөл бүрдэнэ.
Зардлын дүн				5	
Нийт зардал				147,4	

Төлөвлөгөө боловсруулсан: “Эко-үйлчилгээ” ТББ

Төлөвлөгөө хамтран боловсруулсан: ШУА-ийн Биологийн хүрээлэн Хөхтний экологийн лаборатори

3.7.Стратегийг хэрэгжүүлэх эхний нэг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, санхүүгийн эх үүсвэр

Менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаануудыг цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж, зорилго зорилтоо ханган биелүүлэхийн тулд хэрэгцээт санхүүжилтийг бүрдүүлсэн байх шаардлагатай. Менежментийг хэрэгжүүлэх орлогыг дараах эх үүсвэрүүдээс бүрдүүлнэ.

- “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай” хуульд үндэслэсэн орлого;
- Орон нутгийн төсөв;
- Агнуурын санг хамгаалах ажлыг дэмждэг төслүүдийн дэмжлэг;
- Олон улсын болон гадаадын бусад байгууллагын тусламж;

Хэнтий аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан асуудлуудаас 2017-2018 онд хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тоймлон танилцуулбал:

Ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгаагаар санал болгосон агнуурын бүс нутагт малчдын бүлэг нөхөрлөл үүсгэн чадавхжуулах ажлын хүрээнд:

- Нарийвчилсан агнуур зохион байгуулалтын судалгааг монгол тарвага, цагаан зээр, агнуурын шувууд, голуудын загсан дээрх хийлгэх
- Агнуурын бүс нутгийн хилийн цэс, зааг хэмжээг нарийвчлан тогтоох
- Орон нутгийн иргэд, малчдыг бүлэг нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулж, агнуурын санг эзэмшигчтэй болгон, тэдгээрийг чадавхжуулах

Бүс нутгийн ховор болон агнуурын ач холбогдолтой хөхтөн амьтдын байршил нутгийг тогтворжуулах, тоо толгойг өсгөн нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

- Орон нутгийн малчдын бүлэг нөхөрлөлийг мониторинг судалгааны арга зүйд сурган дадлагажуулах, тэдгээрт тулгуурлан мониторинг судалгааг тогтмолжуулах
- Амьтдын байршил нутгийг тогтворжуулахад чиглэсэн биотехникийн арга хэмжээг, тухайлбал булаг шанд задгайлах, өвс тэжээл тавьж өгөх гэх мэт үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх

- Дээрх агнуурын болоод ховор амьтдын популяцийн нөхөн үржил, төлжилд шууд болон дам байдлаар нөлөөлж буй хүрээлэн буй орчны хүчин зүйлийн талаарх судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, тэдгээрийн санал зөвлөмжийг менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх
- Бүс нутгийн ан амьтан, тэдгээрийг зүй зохистой хайрлан хамгаалах чиглэлээр сургалт, сурталчилгааны материал хэвлэн тараах гэх мэт ажлыг нэн тэргүүнд хийж гүйцэтгэвэл зохино.

Хэнтий аймгийн 2018 онд 152 толгой цагаан зээрийг ахуйн зориулалтаар агнуулна гэж тооцвол нэг зээрийн агнуурын зөвшөөрөл 110000 төгрөг буюу аймаг, орон нутгийн төсөвт $152 \times 110000 = 16\,720\,000$ төгрөг болж байгаа ба үүний 50 хувийг буюу 8 360 000 төгрөг болно. 4 угалз, 31 халиун буга тусгай зориулалтаар агнуулна гэж тооцвол нэг угалзын агнуурын төлбөр, хураамж нийлээд ойролцоогоор 126 000 доллар, Нийт орон нутагт тусгай зориулалтаар 126 000 доллар буюу 308 700 000 төгрөг, ахуйн зориулалтаар 16 720 000 төгрөг нийт 325 420 000 сая төгрөг болж байгаа ба үүний 50 хувийг ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох журмын 6.6-д зааснаар болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн 2018 онд агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхэд зарцуулах боломжтой.

Хэрэгжүүлэх байгууллага: Аймгийн БОАЖГ 2017-2022 онуудад хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагууд, ТББ-ын дэмжлэгтэй, нөхөрлөлүүдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

Санхүүжилт: Үндсэн санхүүжилт нь аймгийн төсвөөс хийгдэх боловч бусад эх үүсвэрээс дэмжлэг авч болно.


3.8. Агнуурын бүс нутгийн танилцуулга, холбогдох газрын зураг, хилийн зааг, хэмжээ

Цагаан зээрийн агнуурын бүс нутгийн санал. Тус аймгийн нутагт өргөн тархсан амьтны нэг бөгөөд 2017 оны 8-9 сард хийгдсэн ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгаагаар **32041,0 км² нутагт 31338 (95% CI=12964-50939) толгой цагаан зээр нэгж талбайд 9,4 нягтшилтайгаар** тархан байршиж байгааг тогтоов.

Агнуурын туруутан амьтны нөөцийг ашигладаг дэлхий нийтийн туршлагаас үзэхэд нийт тоо толгойн 10%-ийг ашиглахад тоо толгой, нөөцөд сөрөг нөлөөгүй гэдэг. Тэгэхдээ

агнуур хийх тухайн нутгийн 1000 га дахь нягтшилыг харгалзан үзэх нь зүйтэй юм. Аймгийн хэмжээнд 1000 га-д 4.5 тоо толгойгоос дээш нягтшилтай бол жилд 10-аас дээшгүй хувийг спорт агнуурын чиглэлээр тусгай зөвшөөрлөөр агнан ашиглаж болох юм (Амгалан, 2000).


Судалгааны ажиглагдсан цагаан зээрийн популяцийн бүтэц, нөхөн үржлийн чадавх, бүс нутгийн онцлог зэргийг харгалзан авч үзвэл тус амьтныг зүй зохистой ашиглах, хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэний үндсэн дээр байгаль, цаг уурын тааламжтай нөхцөлд өнөөгийн байдлаар Хэнтий аймгийн хэмжээнд 152 хүртэл толгой цагаан зээрийг ахуйн зориулалтаар Монгол улсын Амьтны тухай хууль, түүнтэй нийцэх хууль тогтоомжид заасан хугацаанд агнан ашиглах боломжтой байна.



Зураг 15. Санал болгож буй цагаан зээрийн агнуурын бүс нутаг

Бүс нутгийн цагаан зээр нь улирлын байдлаар нүүдэллэн орж ирэн, популяцийн тоо толгой нь 12964-50939 мянгын хооронд хэлбэлздэг байна. Цагаан зээрийн агнуурын бүс нутгийг тогтоохдоо 2009, 2014, болон 2017 оны судалгааны үр дүнг харьцуулан тус амьтны цөм байршил нутгийг тодорхойлсны үндсэн дээр тогтоосон болно. Гэсэн хэдий ч нүүдлийн амьдралтай уг зүйл амьтны хувьд агнуурын бүс нутгийн хилийн цэсийг нарийвчлан тогтоон өгөх нь биологийн болон экологийн үүднээс учир дутагдалтай учир тухайн жилийн ургамлын гарц, улирлын өнгө, хээрийн судалгааны мэдээ баримтанд тулгуурлан агналтыг явуулах нь зохимжтой гэж үзэж байна.

Халиун буга агнуурын бүс нутгийн санал. Сүүлийн жилүүдэд тус аймгийн нутагт тоо толгой өсөж байгаа амьтан болох халиун буга нь **10662,5 км² нутагт байршил нутгийн 1,2 бодгаль ноогдох нягтшилтайгаар 3079±236 халиун буга** байх боломжтой. Тус нутгийн халиун бугын тоо толгой хэдийгээр өсөж байгаа нь сайшаалтай боловч агнуурын шаардлага хангасан халиун буга хээрийн хайгуул судалгаагаар 31 байна.




Зураг 16. Санал болгож буй халиун бугын агнуурын бүс нутаг

Тусгай зориулалтаар ан агнуур хийхэд бус, харин *тухайн нутагт байгаль хамгаалах малчдын бүлэг, нөхөрлөлийг үүсгэн чадавхжуулах, түүнд тулгуурлан уг амьтныг хамгаалах өсгөн үржүүлэх цогц үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх зорилгоор* янгир ямаа, аргаль хонины тодорхой нөөц бүхий бүс нутгийг санал болгож байна. Өөрөөр хэлбэл байнгын хяналт, мониторинг хийдэг болсноор тус нутгийн халиун бугын тоо толгой өсөн нэмэгдэх биологийн бүрэн чадамжтай болох төдийгүй популяцийн тоо толгой, хөдлөл зүйг таньж тодорхойлох боломж бүрдэх болно.


Монгол тарвага хамгааллын бүс нутгийн санал. Монгол тарваганы цөм байршил нутаг, орон нутгаас ирүүлсэн саналд үндэслэн агнуурын бүс нутгийг тус аймгийн Дэлгэрхаан, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Баян-Адрага, Батноров, Норовлин сумдын нутагт нийт 3759.5 км² нутгийг сонгон авав.

Тус аймгийн монгол тарваганы гол байршил нутгийг хамарсан төдийгүй популяцийн нөхөн үржлийн чадавх өндөртэй нутаг.



Зураг 17. Санал болгож буй монгол тарваганы хамгааллын бүс нутаг

Загас хамгааллын бүс нутгийн санал. Бага цагаан толгой, Эрдэнэ уулын тал, Баян эрхтийн уул, Овооь толгой, Соёлго толгой зэрэг газруудад хамгаалалтанд авах хэрэгтэй. Хэнтий аймгийн Хэрлэн голын хэсгийн нийт гадаргын талбай **24.284 км кв талбайд агнуурын 1347 толгой загас, 1 км.кв талбайд 18 толгой агнуурын загас** оногдож байна.



Зураг 18. Санал болгож буй монгол загас хамгааллын бүс нутаг

Хүснэгт 15. Хэнтий аймгийн хэмжээнд агнаж, ашиглаж болох ан амьтад

Зүйлийн нэр	Аргаль хонь
Нийт нөөц	505
Агнаж, ашиглах хэмжээ /1%/	4
Зүйлийн нэр	Цагаан зээр
Нийт нөөц	31338
Агнаж, ашиглах хэмжээ /0.4%/	152
Зүйлийн нэр	Халиун буга
Нийт нөөц	3079
Агнаж, ашиглах хэмжээ /1%/	31
Зүйлийн нэр	Бор гөрөөс
Нийт нөөц	3398
Агнаж, ашиглах хэмжээ /1%/	34
Зүйлийн нэр	Зэрлэг гахай
Нийт нөөц	1757
Агнаж, ашиглах хэмжээ /2%/	36
Зүйлийн нэр	Саарал чоно
Нийт нөөц	2403
Агнаж, ашиглах хэмжээ /2%/	48
Зүйлийн нэр	Шар үнэг
Нийт нөөц	3349±147
Агнаж, ашиглах хэмжээ /5%/	669
Зүйлийн нэр	Хярс үнэг
Нийт нөөц	924
Агнаж, ашиглах хэмжээ /5%/	185
Зүйлийн нэр	Нохой зээх
Нийт нөөц	344
Агнаж, ашиглах хэмжээ /7%/	24
Зүйлийн нэр	Халздай дорго
Нийт нөөц	1341
Агнаж, ашиглах хэмжээ /7%/	94
Зүйлийн нэр	Чандага туулай
Нийт нөөц	1046
Агнаж, ашиглах хэмжээ /10%/	104

ДӨРӨВ. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ, МОНИТОРИНГ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР

4.1. Үнэлгээ мониторинг

Менежментийн төлөвлөгөөний биелэлт нь төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж шалгуур үзүүлэлтэд заагдсан үр дүнд хүрснээр хангагдана.

Менежментийн төлөвлөгөөний зорилтуудыг бүрэн биелүүлэх нь талуудыг бүрэн, идэвхтэй оролцуулсан эсэх, хэрэгжүүлэх үүрэг бүхий бүтэц нь ажлын арга барил, зохион байгуулалтаа шаардлагад нийцүүлэн шинэчилж чадсан эсэхээс ихээхэн хамаарах юм.

Менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хангах ажлыг зохион байгуулахын зэрэгцээ хяналт тавих, үр дүнг тооцох байгууллага нь аймгийн БОАЖГ юм.

Менежментийн төлөвлөгөөнд хяналт мониторинг хийх чиглэлийг доорх байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Бүлэг нөхөрлөлүүд болон нутгийн иргэд, хуулийн этгээд хэрхэн чадавхажсан, агнуурын байршил болон бүс нутгийн хамгаалалтын ажилд хэр зэрэг идэвхтэй оролцож байгаад,
- Агнуурын зүйлүүдийн нөөц, амьдрах орчны байдал, тэдгээрийн хамгаалалтын чадавхад гарсан өөрчлөлт нь менежментийн төлөвлөгөөний зорилтыг ханган биелүүлэх шаардлагын хэмжээнд хүрч байгаа эсэхэд,
- Ховор болон агнуурын ач холбогдолтой ан амьтдын хамгаалалт, ашиглалт нь тавигдаж буй шаардлага, зарчимд хир зэрэг нийцтэй болсон, байгальд болон нутгийн иргэдийн амьжиргаанд хэрхэн нөлөөлж байгаад,
- Орон нутгийн удирдлага, нөхөрлөлүүдийн гишүүдийг байгаль хамгаалах хууль, тогтоомжийг таниулах, экологийн мэдлэг олгох сургалтад хэрхэн хамруулсан, энэ нь үр дүнд хүрч байгаа эсэхэд,
- Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр агнуурын амьтны популяци, амьдрах орчинд өөрчлөлт гарсан эсэх зэрэгт чиглэсэн мониторинг хийх нь зохистой.

Аймгийн БОАЖГ-аас аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад мониторинг ба үнэлгээ хийж болно.

Менежментийн төлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлэх явцад бэрхшээл гарах, зөрчил, доголдол илрэх нь мэдээж бөгөөд үүнд зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэр гарган засаж залруулах ба хариуцаж буй байгууллага, иргэн, албан тушаалтнуудад арга

хэмжээ авах, урамшуулах зэрэг хариуцлагын механизм шударга үйлчлэх ёстой. Энэхүү хуулийн дагуу авсан арга хэмжээ нь талууд, оролцогчдод жигд үйлчлэх ба бусдад үр нөлөө өгөхүйц байх хэрэгтэй.

Төрийн хяналт, үнэлгээ: Аймгийн БОАЖ-ны газар болон суманд байгаль орчны талаарх хууль тогтоомжуудын хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагч, санхүү, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьдаг татварын байцаагч, цагдаагийн тасаг ажилладаг бөгөөд үүрэг хариуцлагынхаа дагуу хяналт тавьж ажиллана.

Олон нийтийн хяналт, үнэлгээ: Энэхүү менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад орон нутгийн иргэд, байгаль орчны мэргэжлийн байгууллагууд хяналт тавих эрхтэй.

4.2. Амьтныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах үйл ажиллагааны удирдлагын бүтэц

Аймгийн хэмжээнд ан амьтны бодлого боловсруулах үүрэг нь ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтэст байна. Аймгийн БОАЖГ нь амьтны аймгийг хамгаалах, популяцийг сэргээх, зүй зохистой ашиглах асуудлыг зохион байгуулах зэргээр бодлогын хэрэгжилтийг зохион байгуулдаг.

Амьтны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын газар, БОАЖГ хэрэгжүүлдэг. Гэсэн хэдий ч тусгай зөвшөөрлийн эрхийг төрийн захиргааны төв байгууллагаас олгодгоос ховор амьтны зүй зохистой ашиглалтын асуудлыг удирдан зохион байгуулахад бэрхшээлтэй байдаг.


Бизнесийн төлөөлөл, бусад талуудтай хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах шаардлага бий. Тухайлбал зөвхөн агнуур биш ховор ан амьтдын судалгаа шинжилгээний төсөл хөтөлбөр, олон улсын болон дотоодын судалгаа шинжилгээний байгууллагуудтай хамтын ажиллагааны хэрээ хэлэлцээрийг шууд холбоо тогтоож, байгаль орчин, ан амьтдын судалгаа шинжилгээг хамтран зохион байгуулах нь агнуурын санг хамгаалах, тогтвортой ашиглах ач холбогдолтой. Үүнд мэдээж боловсон хүчнээ чадавхжуулах шаардлага, хэрэгцээ гарна.

Удирдлага зохион байгуулалтын чадавхажсан бүтэцтэй байх нь менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол нөхцөл юм.

Удирдлагын үндсэн бүтэц нь аймгийн ЗДТГ, БОАЖГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс, агнуурын бүс нутгийг менежментээр хариуцагч, орон нутгийн төлөөлөл оролцсон “АБН-ийн зөвлөл” байхаар төлөвлөв.

Аймгийн БОАЖГ нь энэхүү менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах үндсэн үүрэгтэй. Мөн хамтран оролцогчдын эрх үүргийг тодорхойлон, уялдуулах үүрэг хамаарна. Энэ зөвлөл нь оролцогч талуудыг чадавхжуулах, эрхийг нь хамгаалах зорилготой байх юм (1-р бүдүүвч).

1-р бүдүүвч. Хэнтий аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлагын бүтэц



Санал болгож буй энэ бүтцээр ажилласнаар тулгарч буй асуудлаа өөрсдөө тодорхойлох, шийдвэр гаргах боломжтой болох юм. Зөвлөл нь аймаг, сумын төр захиргааны байгууллага, ТББ-ууд, нөхөрлөлүүд, гадаад, дотоодын болон олон улсын байгууллага иргэдтэй харилцан гэрээтэй ажиллаж хамтын ажиллагаагаа өргөжүүлэх замаар зах зээлд тогтвортой ажиллах боломж нэмэгдэнэ.

4.3. Төсөв, санхүүгийн эх үүсвэр

Энэхүү Менежментийн хөтөлбөрийн хэрэгжилт нь тухайн баг санхүүгийн эх үүсвэрийг хэрхэн бүрдүүлж байна, төсөл, хөтөлбөр, бусад урамшууллын арга хэмжээнд хир сайн оролцож байна гэдгээс хамаарна. Улсын төсвөөс оруулах хөрөнгө оруулалт нь хэдийгээр хязгаарлагдмал байгаа ч менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх суурь

хөрөнгө оруулалт болно. Өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үзвэл төсвийн хөрөнгө оруулалт нь БОАЖГ-ын захиргааны зардал болон албан хаагч, байгаль хамгаалагчдын ажлын хөлсийг л өгөх хэмжээнд байгаа болно. Иймээс менежментийн төлөвлөгөөний үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрүүд болон ямар үйл ажиллагаанаас Агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч орон нутгийн байгаль хамгаалах нөхөрлөл ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай орлогыг бүрдүүлэх тал дээр нарийвчилсан дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Хариуцлагатай байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, агнуурын нөөц ашигласны хураамж гэх зэрэг татвар, хураамжаас олох орлогыг менежментийн төлөвлөгөөний үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шууд зарцуулах хөрөнгийн эх үүсвэр хэмээн ойлгох нь зөв.

Менежментийн төлөвлөгөөнд заагдсан зарим үйл ажиллагааг, тухайлбал агнуурын амьтдын популяцийн тооллого, бүс нутгийн экосистемийн төлөв байдлын судалгааг үндэсний болон олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд байгаль орчны салбарт үйл ажиллагаа төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран төсөл хэрэгжүүлэх замаар гүйцэлдүүлж болох юм. Түүнчлэн энэхүү төсөл хэлбэрээр хэрэгжих үйл ажиллагаанд байгаль орчны боловсрол, ард иргэдийн оролцоотой мониторинг хийх зэрэг чиглэлүүд хамрагдан, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлж болох юм. Бүс нутгийн байгаль, нийгэм, соёлын үнэ цэнийг бодитоор үнэлэх, тэдгээр нөөцийн төлөв байдалд шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлэлт дүгнэлт өгөхөд эрдэм шинжилгээ, судалгааны ажлын цар хүрээг нэмэгдүүлэх шаардлагатай. Энэ нь өртөг өндөртэй үйл ажиллагаа байдаг тул орон нутгийн засаг захиргаа, ба агнуурын бүс нутагт ажиллаж буй бүлэг нөхөрлөлүүд ШУА, түүний холбогдох хүрээлэн төвүүд, мэргэжлийн судлаачидтай хамтын ажиллагааны гурвалсан гэрээ байгуулан шинжлэх ухааны нийтлэг зорилгын хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь үр дүнтэй болох юм.

Орон нутгийн захиргаа, нутгийн иргэдийн холбоо зэрэг байгууллагуудтай гэрээ байгуулах замаар талуудын нийтлэг сонирхлын хүрээнд зарим нэг үйл ажиллагааг хамтран гүйцэтгэх нь санхүүгийн хязгаарлагдмал нөөцийг зохистой хуваарилах өөр нэг арга болохыг санах нь зүйтэй.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Байгаль орчны тухай Монгол Улсын хуулиуд. УБ., 2007, 2008
2. Зэрлэг ургамал, амьтны аймгийн ховордсон зүйлийн олон улсын худалдааны тухай конвенц. I-II хавсралт 2003 CITES.
3. Монгол Улсын Засгийн газар, 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, УБ, 1998
4. Монгол улсын Засгийн газрын тогтоол. 2002. 1264. 1 хавсралт. Ховор амьтны жагсаалт.
5. Монголын биологийн төрөл зүйлийн үндэсний хөтөлбөр, УБ, 1998
6. Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах чадавхын үнэлгээ. УБ, 2003
7. Монгол Улсын Улаан ном, УБ., 1955, 1997
8. Мягмарсүрэн Д, Энэбиш Д. Монгол Улсын дархалсан газар нутгууд. УБ.,2008
9. Оюунгэрэл Б., Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг. 2004
10. Энэбиш. Д,Гүнджалам.Б,Байгаль орчны төлөвлөлтийн ажилтны гарын авлага. УБ.,2010

ХАВСРАЛТ 1

МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН АРГА ЗҮЙ

Нэгдүгээр үе шат буюу тодорхойлох: Энэ нь Хэн? Хаана? Юүг? хамгаалах гэдгийг тодорхойлно.

- Тухайн газар нутгийг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, бодлого боловсруулах, хуулийг хэрэгжүүлэх гэх мэт бүх талуудаас бүрдсэн төлөвлөлтийг боловсруулах үндсэн нэгж буюу хамтран ажиллах талуудыг тодорхойлох;
- Тухайн агнуурын бүс нутгийн хил хязгаарыг тодорхойлох;
- Хил хязгаарыг тодорхойлсон агнуурын бүс нутгийн нутаг дэвсгэр дэхь биологийн олон янз байдлаас судалгаа, туршлагадаа тулгуурлан сонголт хийн юуг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах вэ гэдгийг тодорхойлох;

Үүнд: **1.Амьтан, ургамлын зүйл,2. Бүлгэмдэл,3.Экосистем** зэрэг багтана. Эдгээр зайлшгүй хамгаалахаар сонгож авсан амьтан, ургамлын зүйл, бүлгэмдэл, экосистем нь төлөвлөлт хийж буй эко-бүс нутгийн биологийн олон янз байдлыг төлөөлж чадахуйц байх ёстой.

Хоёрдугаар үе шат буюу байгаль хамгааллын зорилго, түүнийг хэмжих хэмжүүрийг боловсруулах:

2.1. Хамгаалахаар сонгож авсан биологийн олон янз байдлын экологийн чадамжид тулгуурлан байгаль хамгааллын зорилгыг тодорхойлно. Өөрөөр хэлбэл сонгож авсан биологийн олон янз байдлын экологийн түлхүүр шинж чанарт тулгуурлан үнэлгээ өгнө. Үнэлгээг өнгөрсөн, одоогийн байдал, ирээдүйд хүсэн хүлээж буй үр дүн гэсэн байдлаар өгнө. Энэ нь бидний сонгож авсан биологийн олон янз байдал байгаль дээр нөхөн сэргээгдэх чадвар ямар байгааг үнэлж өгдөг. Тухайлбал шинэсэн ойг бид зайлшгүй хамгаалах бүлгэмдлээр сонгосон гэж үзвэл түүний экологийн гол түлхүүр процесс нь нөхөн ургалт байж болно. Өөрөөр хэлбэл нөхөн ургалт зогссон тохиолдолд тухайн бүлгэмдэл устах болно гэдгийг илтгэж байна. Сонгож авсан биологийн олон янз байдлыг нөхөн сэргээж хамгаалахын тулд тэрхүү экологийн түлхүүр шинж чанар дээр тулгуурлан төлөвлөгөөний зорилгыг боловсруулах болно.

Гуравдугаар үе шат: Хамгаалахаар сонгосон биологийн олон янз байдалд учрах аюул, дарамт түүнийг бий болгож байгаа эх үүсвэр, шалтгааныг

тодорхойлох; Сонгож авсан биологийн олон янз байдалд ямар аюул одоогоор учирч байна, ямар дарамт ирээдүйд учирч болзошгүй вэ гэдгийг үнэлнэ. Аюулыг тодорхойлохдоо тухайн сонгосон биологийн олон янз байдлын экологийн түлхүүр шинж буюу чадамжид тулгуурлах юм. Экологийн гол шинж чанар буюу чадамжид нөлөөлж байгаа аюулыг тодорхойлохдоо *аюулын зэрэглэл, цар хүрээ* гэсэн шалгуураар үнэлгээ өгнө. Үүний дараа аюулыг үүсгэж байгаа эх үүсвэрийг мөн тодорхойлно. Аюулыг бий болгож байгаа учир шалтгаан эх үүсвэрийг тодорхойлохдоо тухайн аюулд оруулж байгаа *хувь хэмжээ, дарамтыг устгаж* чадах эсэх гэсэн шалгуураар үнэлгээ өгнө.

Дөрөвдүгээр үе шат: Зорилт, үйл ажиллагааг тодорхойлох;

4.1. Ямар үр дүнд хүрэхийг хүсэж байгаа зорилгодоо хүрэхийн тулд биологийн олон янз байдалд учирч байгаа аюулыг бууруулахад чиглэгдсэн зорилтыг хэмжиж болохуйц, тодорхой цаг хугацаатайгаар тодорхойлсон байна.

4.2. **Тухайн зорилтод хүрэх хамгийн шилдэг бөгөөд үр дүнтэй арга бүхий**

үйл ажиллагааг тодорхойлох; Үйл ажиллагааг төлөвлөхдөө хэн, ямар хугацаанд, ямар санхүүжилтээр хэрэгжүүлэхийг хамтад нь төлөвлөж болдог.

Нэг зорилтод хүрэхийн тулд нэг, түүнээс дээш үйл ажиллагааг төлөвлөнө.

Жишээ:

Зорилт-1: 2022 он гэхэд хууль бус ан агнуурыг 2017 оныхтой харьцуулахад 2 дахин бууруулна.

Үйл ажиллагаа 1.1: Агнуурын санг эзэмшигчтэй болгох


Үйл ажиллагаа 1.2: Хяналт шалгалт, мониторингийг тогтмолжуулах

Үйл ажиллагаа 1.3: Сургалт, сурталчилгаа хийх гэх мэт

Үр дүнг тодорхойлох илтгүүр/ индикаторыг тодорхойлох; Тухайн зорилт сонгож авсан биологийн олон янз байдалд хэрхэн нөлөөлснийг хэмжих нэгжийг тодорхойлно. Нэг зорилтод хэдэн ч индикатор байж болно. Индикатор нь хэмжигдэхүйц байх ёстой.

Тухайлбал: Зорилт-1: 2022 он гэхэд хууль бус ан агнуурыг 2017 оныхтой харьцуулахад 2 дахин бууруулна.

Индикатор: Хууль бус агнуурын зөрчлийн тоо



Шүлхийн тархалтын загвар (эх сурвалж Д. Энхбилэг)